



# Харилцаа холбооны зах зээлийн мэдээлэл

Улаанбаатар 2023

Энэхүү харилцаа холбооны зах зээлийн мэдээллийн эмхэтгэлийг

Харилцаа холбооны зохицуулах хорооны

Зах зээл, үнэ тарифын газрын

Судалгаа, шинжилгээний хэлтсээс боловсруулав.

[www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn) , 976-11304258

2023 он

## Агуулга

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт .....	iv
Зурган мэдээллийн жагсаалт.....	vi
1. Танилцуулга .....	1
2. Тусгай зөвшөөрөл .....	3
3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	4
3.1 Харилцаа холбооны үйл ажиллагааны орлого .....	5
3.2 Төсөвт төвлөрүүлсэн орлого .....	6
3.3 Хөрөнгө оруулалт.....	8
4. Харилцаа холбооны сүлжээ .....	9
4.1 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт .....	10
4.2 Харилцаа холбооны сүлжээний урт .....	11
4.3 Улс хоорондын сүлжээний үйлчилгээ .....	12
4.4 Улс хоорондын транзит үйлчилгээ .....	13
4.5 Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ .....	13
5. Үүрэн холбооны үйлчилгээ .....	15
5.1 Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт .....	15
5.2 Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо.....	18
5.3 Үүрэн холбооны ачаалал/хэрэглээ.....	24
5.3.1 Ярианы ачаалал.....	24
5.3.2 Мессеж ба дата хэрэглээ.....	25
6. Суурин интернэт үйлчилгээ .....	27
6.1 Суурин интернэт үйлчилгээний орлого .....	27
6.2 Суурин интернэт хэрэглэгчийн тоо.....	28
6.3 Суурин интернэтийн хэрэглээ .....	31
7. Суурин телефон үйлчилгээ.....	32
7.1 Суурин телефон үйлчилгээний орлого .....	33
7.2 Суурин телефон хэрэглэгчийн тоо .....	34
7.3 Суурин телефон үйлчилгээний ачаалал.....	36
8. Олон суваг дамжуулах үйлчилгээ .....	37
8.1 Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого .....	37
8.2 Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо.....	39
9. Телевизийн үйлчилгээ .....	43
10. Радиогийн үйлчилгээ.....	46

11.	Шуудангийн үйлчилгээ .....	48
11.1	Шуудангийн үйлчилгээний орлого .....	49
11.2	Шуудангийн илгээмж солилцоо .....	51
11.2.1	Дотоодын шуудангийн илгээмж солилцоо .....	51
11.2.2	Улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо .....	52
12.	Хүний нөөц .....	53
	Хавсралт .....	55

## Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Хүснэгт 1. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, үйл ажиллагааны чиглэлээр (тэрбум төгрөг) .....	6
Хүснэгт 2. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, үйл ажиллагааны чиглэлээр (тэрбум төгрөг) .....	7
Хүснэгт 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр (тэрбум төгрөг) .....	8
Хүснэгт 4. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2022 он .....	9
Хүснэгт 5. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний төрлүүд .....	9
Хүснэгт 6. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	10
Хүснэгт 7. Харилцаа холбооны хот, хот хоорондын дамжуулах сүлжээний урт (км), оноор .....	11
Хүснэгт 8. Шилэн кабелийн сүлжээний урт (км), 2022 он .....	11
Хүснэгт 9. Улс хоорондын нийт транзит урсгал ба орлогын хэмжээ, оноор .....	13
Хүснэгт 10. Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн орлого, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	14
Хүснэгт 11. Сансрын холбооны үйлчилгээний хэрэглэгчийн тоо .....	14
Хүснэгт 12. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь .....	15
Хүснэгт 13. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	16
Хүснэгт 14. Үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлогын бүтэц .....	17
Хүснэгт 15. Үүрэн холбооны нэвтрэлтийн түвшин .....	19
Хүснэгт 16. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо .....	19
Хүснэгт 17. Үүрэн холбооны нийт бааз станцын тоо, технологийн төрлөөр .....	20
Хүснэгт 18. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо бүс, байршлаар .....	21
Хүснэгт 19. Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж дата хэрэглээ .....	26
Хүснэгт 20. Хөдөлгөөнт өргөн зурвасын смарт бокс ашиглан үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо .....	26
Хүснэгт 21. Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхитэй хэрэглэгчийн тоогоор .....	27
Хүснэгт 22. Суурин интернэт үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	27
Хүснэгт 23. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр .....	31
Хүснэгт 24. Суурин интернэт үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ .....	32
Хүснэгт 25. Суурин телефон үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхитэй хэрэглэгчийн тоогоор .....	32
Хүснэгт 26. Суурин телефон үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	33
Хүснэгт 27. Суурин телефон хэрэглэгчийн тоо, хэрэглэгчийн төрлөөр .....	35
Хүснэгт 28. Суурин телефон хэрэглэгчийн тоо, байршлаар .....	36
Хүснэгт 29. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхитэй хэрэглэгчийн тоогоор .....	37
Хүснэгт 30. Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	38
Хүснэгт 31. АйПиТВ үйлчилгээний хэрэглэгчийн тоо, төрлөөр .....	41

Хүснэгт 32. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр .....	42
Хүснэгт 33. Телевизийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр .....	43
Хүснэгт 34. Телевизийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	44
Хүснэгт 35. Телевизийн үйлчилгээний 2022 оны орлого /Тэрбум төгрөг/.....	44
Хүснэгт 36. Телевизийн үйлчилгээний 2022 оны орлогын бүтэц .....	45
Хүснэгт 37. Радиогийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр .....	46
Хүснэгт 38. Радиогийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	47
Хүснэгт 39. Радиогийн үйлчилгээний 2022 оны орлого, байршлаар .....	47
Хүснэгт 40. Радиогийн үйлчилгээний орлогын бүтэц, 2022 он.....	47
Хүснэгт 41. Шуудангийн тусгай зөвшөөрлийн тоо .....	48
Хүснэгт 42. Шуудангийн сүлжээ болон үндсэн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2022 он .....	48
Хүснэгт 43. Улс хоорондын илгээлтийн үйлчилгээ үзүүлж буй чиглэл, үйлчилгээ эрхлэгчийн тоо.....	49
Хүснэгт 44. Шуудангийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт .....	49
Хүснэгт 45. Нийт шуудангийн илгээмж солилцооны тоо .....	51
Хүснэгт 46. Дотоодын шуудангийн илгээмж солилцооны тоо.....	51
Хүснэгт 47. Дотоодын буухиа шуудан солилцооны тоо .....	51
Хүснэгт 48. Улс хоорондын шуудан солилцооны тоо .....	52
Хүснэгт 49. Улс хоорондын буухиа шуудан солилцоо.....	52
Хүснэгт 50. Нийт ажилтны тоо, салбар болон үйлчилгээний төрлөөр.....	53

## Зурган мэдээллийн жагсаалт

Зураг 1. Зөвшөөрлийн тоо, оноор.....	3
Зураг 2. Харилцаа холбооны үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр (2022 оны жилийн эцсийн байдлаар) .....	4
Зураг 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2020-2022 он.....	5
Зураг 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, оноор .....	5
Зураг 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, оноор.	7
Зураг 6. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оноор.	8
Зураг 7. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, оноор .....	10
Зураг 8. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил, 2022 он .....	12
Зураг 9. Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчдийн нийт урсгалын багтаамж: Гбит/сек .	13
Зураг 10. Сансрын холбооны үйлчилгээний орлого, оноор /тэрбум төгрөг/.....	14
Зураг 11. Үүрэн холбооны нийт орлого /тэрбум.төг/ .....	16
Зураг 12. Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/ .....	17
Зураг 13. Үүрэн холбооны хөрөнгө оруулалт төсөв төвлөрүүлсэн орлого .....	18
Зураг 14. Үүрэн холбооны идэвхитэй хэрэглэгчийн тоо, оноор .....	18
Зураг 15. Хэрэглэгчийн төлбөрийн нөхцөл .....	19
Зураг 16. 3G, 4G/LTE хэрэглэгчийн тоо. мян .....	20
Зураг 17. Үүрэн холбооны нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2022 он.....	22
Зураг 18. Үүрэн холбооны 3G нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2022 он. ....	22
Зураг 19. Үүрэн холбооны 4G/LTE нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2022 он.....	22
Зураг 20. M2M хэрэглэгчийн тоо.....	23
Зураг 21. Ухаалаг төхөөрөмжийн төрөл.....	23
Зураг 22. Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо .....	24
Зураг 23. Үүрэн холбооны сүлжээн дэх ярианы ачаалал, сая минут .....	24
Зураг 24. Үүрэн холбооны хэрэглэгчдийн нэг сарын дундаж мессеж болон дата хэрэглээ	25
Зураг 25. Үүрэн холбооны хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ /ТВ/.....	26
Зураг 26. Суурин интернэт үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/ .....	28
Зураг 27. Интернэтийн үйлчилгээний орлогын бүтэц .....	28
Зураг 28. Суурин интернэт хэрэглэгчийн тоо.....	29
Зураг 29. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, байршлаар .....	29
Зураг 30. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр.....	30
Зураг 31. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар .....	30
Зураг 32. Суурин телефон үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/.....	33
Зураг 33. Суурин телефон үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/ .....	34
Зураг 34. Суурин телефон холбооны орлогын бүтэц 2022 он .....	34
Зураг 35. Суурин холбооны идэвхитэй хэрэглэгчийн тоо.....	35
Зураг 36. Суурин холбооны ярианы ачаалал /сая минут/ .....	36
Зураг 37. Олон суваг дамжуулах үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/.....	38
Зураг 38. Олон суваг дамжуулах үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төгрөг/ .....	38
Зураг 39. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхитэй хэрэглэгчийн тоо .....	39
Зураг 40. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршлаар .....	39
Зураг 41. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршил ба технологиор .....	40

Зураг 42. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгч, технологийн төрлөөр .....	40
Зураг 43. АйПиТВ үйлчилгээний нийт хэрэглэгчийн тоо, оноор.....	41
Зураг 44. АйПиТВ хэрэглэгчийн тоо, байршлаар.....	41
Зураг 45. Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн орлого /тэрбум төгрөг/ .....	43
Зураг 46. Радиогийн үйлчилгээний орлого /сая төгрөг/ .....	46
Зураг 47. Шуудангийн нийт үйлчилгээ эрхлэгчид болон Монгол Шуудан ХК-ийн орлогын харьцуулалт, оноор (сая төгрөг) .....	50
Зураг 48. Шуудангийн үйлчилгээний орлогын бүтэц .....	50
Зураг 49. Нийт ажилтны тоо, оноор.....	53

Нийт орлого  
**1,859.0**  
тэрбум төгрөг

Нийт хөрөнгө  
оруулалт  
**366,8**  
тэрбум төгрөг

Нийт төсөвт  
төвлөрүүлсэн  
орлого  
**324,4**  
тэрбум төгрөг

Нийт ажиллагсдын  
тоо  
**12,688**



**193 мян** M2M төхөөрөмж

**3.1 сая** 4G/LTE хэрэглэгч

**3.6 сая** 3G хэрэглэгч

**4.0 сая** Үүрэн холбооны хөдөлгөөнт  
өргөн зурвасын хэрэглэгч

**4.8 сая** Үүрэн холбооны хэрэглэгч



**475 мян** Суурин  
холбооны хэрэглэгч




**436 мян** Суурин  
интернэт хэрэглэгч




**760 мян** Олон суваг  
дамжуулах үйлчилгээний хэрэглэгч  
(АйПиТВ оролцуулаад)

**372 мян** Ай Пи ТВ  
хэрэглэгч

Сүлжээний урт, км




Интернэтийн нийт  
багтаамж, Gbps




ISP-д гэрээлсэн  
урсгал, Gbps



Дотоодын шуудан солилцоо  
Улс хоорондын шуудан солилцоо



Улс хоорондын шуудангийн  
илгээмжийн солилцоо, сая ширхэг



## 1. Танилцуулга

Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид Зохицуулах хороо гэх) нь Харилцаа холбооны тухай болон бусад холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2022 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны салбарт нийт 628 аж ахуйн нэгж байгууллага, 753 тусгай зөвшөөрлийн хүрээнд харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээр тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн ирүүлсэн үйл ажиллагааны статистик тайлан, мэдээлэлд суурилж, энэхүү зах зээлийн мэдээллийн тайланг боловсруулав.

### *Салбарт гарсан өөрчлөлт*

Монгол Улсын Засгийн газар харилцаа холбоо, мэдээллийн технологийг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэгээр зарлаж, “Цахим үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн ба энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрыг татан буулгаж, “Цахим хөгжил, харилцаа холбооны яам” (ЦХХХЯ)-ыг байгуулсан нь харилцаа холбооны салбар дахь томоохон онцлох үйл явдал байв.

ЦХХХЯ байгуулагдсанаар салбарын бодлогын чиглэл буюу “Цахим үндэстэн” баримтлах чиглэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 дугаар сарын 18-ны А/24 дүгээр тушаалаар баталсан. Тус баримтлах чиглэлд “Монгол Улсын нийгэм эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх” эрхэм зорилгын хүрээнд 2022-2027 онд хэрэгжүүлэх 6 үндсэн зорилт дэвшүүлэн тавьсны нэг нь дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангахад чиглэж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталж, 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэллээ. Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр 2001 оноос мөрдөгдөж ирсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчингүй болж, улмаар төрийн эрх барих байгууллагуудаас баталсан олон төрлийн журмаар зохицуулагдаж байсан тусгай зөвшөөрөл болон зөвшөөрлийг нэгтгэж, нэгдсэн нэг тогтолцоог шинэ хуулиар бий болгохыг зорьж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9-д Харилцаа холбооны зохицуулах хорооноос харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр 14 төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохоор заасан. Энэ төрлүүдийг тодорхойлохдоо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд (ААҮАТЗТХ) заасан үйл ажиллагаануудыг оруулснаас гадна, тусгайлсан хууль,

журмаар зохицуулж байсан тусгай зөвшөөрлүүдийг нэгтгэн тусгаж өгсөн. (Хавсралтаас үзнэ үү.)

Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиудад холбогдох нэмэлт өөрчлөлтүүд орсон бөгөөд Зохицуулах хорооноос баталсан Харилцаа холбооны салбарт үйл ажллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журмыг 2022 оны 12-р сард хүчингүй болгосон. Мөн Зохицуулах хорооноос баталсан бусад журам болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагуудад Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах ажлууд үрэлжлэн хийгдэж байна.

### *Зах зээлийн тойм*

2022 онд үүрэн, суурин телефон холбоо, интернэт, IPTV, шуудан, өргөн нэвтрүүлгийн телевиз, радио болон сүлжээ дэд бүтцийн суурилуулалт үйлчилгээний орлого өсч, нийт дүнгээр 1.8 их наядад хүрсэн. Харин уламжлалт кабелийн телевизийн үйлчилгээ хүрээгээ хумьж, хэрэглэгчийн тоо нь буурч байна. Мөн арилжааны телевизүүдийн орлого буурчээ.

Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэгчид шилэн кабелийн үндсэн сүлжээг 477 км-ээр, интернэтийн гадаад урсгалын багтаамжийг 120 Гбит/сек-ээр тус тус нэмэгдүүлсэн бол үүрэн холбооны 4 оператор компани 2022 онд орон нутагт 448 бааз станц шинээр байгуулж, сүлжээг өргөжүүлсэн байна.

Үүрэн холбоо, үндсэн сүлжээний хөрөнгө оруулалт салбарын нийт хөрөнгө оруулалтын 80 орчим хувийг эзэлж байна.

Үүрэн холбооны идэвхитэй хэрэглэгчийн тоо 4.8 сая, хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо 4 саяд хүрч, хэрэглэгчийн нэг сарын дундаж дата хэрэглээ 13.8 Гбайт болж өмнөх оны дунджаас 2.4 Гбайтаар нэмэгджээ. Мобайл ярианы хэрэглээ тогтмол байгаа бол SMS хэрэглээ буурч байна.


Суурин интернэт хэрэглэгчийн тоо 15 хувиар өсч 436.5 мянга, суурин телефон хэрэглэгчийн тоо 19 хувиар өсч 475.3 хүрсэн бол телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний (ОСДҮ) хэрэглэгчийн тоо 6 хувиар буурч 760,028 болжээ. ОСДҮ-ний хэрэглэгч нийт дүнгээр буурсан ч технологиор нь авч үзвэл АйПиТВ хэрэглэгчийн тоо 16 хувиар өссөн. Эдгээр үйлчилгээний өрхийн нэвтрэлт Монгол Улсын хэмжээнд суурин интернэт 43 хувь, суурин телефон 44 хувь, телевизийн олон сувгийн үйлчилгээ 82 хувьтай байна.

Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж, нийт орлого нь сүүлийн 3 жилд дунджаар 34 хувийн өсөлттэй байна. Ковидын жилүүдэд (2020, 2021 онд) улс хоорондын шуудангийн солилцоо буурсан ч бичиг захидлаас бусад нь буцаж нэмэгдсэн, харин дотоод шуудангийн солилцоонд эерэг нөлөөлөлтэй байж, тогтмол өсөлттэй байна.

## 2. Тусгай зөвшөөрөл

2022 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх нийт 753, мөн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 174 тусгай зөвшөөрөл олгогдсон байгаа нь өмнөх оноос буурсан, харин радио давтамжийн эрхийн бичгийн тоо өссөн үзүүлэлттэй байна. (Зураг 1)

Зураг 1. Зөвшөөрлийн тоо, оноор



Харилцаа холбооны сүлжээ байгуулах (+5), мэдээллийн сүлжээ байгуулах (+3), төлбөртэй телевиз (+5), арилжааны радио (+2), улс хоорондын логистикийн шуудангийн үйлчилгээ (+8) -ний тусгай зөвшөөрлийн тоо 2022 онд нэмэгдсэн бол орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз (-14), харилцаа холбооны үйлчилгээ буюу интернэт (-6) болон улс хоорондын яриа (-2), олон суваг дамжуулах үйлчилгээ (-3), шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээний (-13) тусгай зөвшөөрлийн тоо буурчээ. (Хаалтад нэмэгдсэн болон буурсан тоог тэмдэглэсэн. Эдгээр тоо нь шинээр олгосон болон цуцалсан тооноос ялгаатай болно.)

Ерөнхий чиглэлээр нь авч үзвэл мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр нийт 368, өргөн нэвтрүүлгийн чиглэлээр 240, шуудангийн чиглэлээр 145 тусгай зөвшөөрөл байна.

Зохицуулах хорооноос 2022 онд нийт 176 тусгай зөвшөөрөл олгож, 141 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 38 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ.

Тусгай зөвшөөрлийн тоог эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр нь зураг 2-т харуулсан бөгөөд харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн угсралт суурилуулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нь нийт тусгай зөвшөөрөлд 35 хувийг эзэлж байгаа нь хамгийн их байна. Энэ тусгай зөвшөөрөл нь хөрөнгө оруулалт бага шаарддаг, барьж байгуулсан сүлжээг эзэмшдэггүй, зөвхөн ажил үйлчилгээ гүйцэтгэдгээрээ онцлогтой юм.

Зураг 2. Харилцаа холбооны үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр (2022 оны жилийн эцсийн байдлаар)



Жич: XX-Харилцаа холбооны, РТВ – Радио, Телевизийн

Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн угсралт, суурилуулалтын тусгай зөвшөөрлийн тоог тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоогоор авсан болно.

### 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлого 2022 оны байдлаар 1.8 их наядад хүрсэн нь өмнөх оноос 13.1 хувиар, төсөвт төвлөрүүлсэн орлого 324.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 8 хувиар, үйлчилгээний хамрах хүрээ, техник технологийн сайжруулалт болон чанарын түвшинг хангах чиглэлээр хийгдсэн нийт хөрөнгө оруулалт 366.8 тэр бум төгрөгт хүрч өмнөх оноос 31.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. (Зураг 3.)

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд бүгд өссөн боловч, өсөлтийн хувийг өмнөх онтой харьцуулж үзвэл орлого болон төсөвт төвлөрүүлсэн орлогын өсөлтийн хувь 4 болон 24 пунктээр тус тус буурсан, харин хөрөнгө оруулалтын өсөлт өмнөх жилээс 18 пунктээр нэмэгджээ.

Зураг 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2020-2022 он




### 3.1 Харилцаа холбооны үйл ажиллагааны орлого

Нийт дүнгээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого өмнөх оноос 13 хувиар өссөн ч өсөлтийн хувь нь өмнөх жилтэй харьцуулахад бага байна. Мөн үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл орлогын өсөлт харилцан ялгаатай байгааг хүснэгт 2-оос харж болно.

Нийт орлогын хамгийн их буюу 56%-ийг үүрэн холбооны орлого бүрдүүлдэг хэвээр байна.

Зураг 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, оноор



Хүснэгт 1. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, үйл ажиллагааны чиглэлээр (тэрбум төгрөг)

Салбар	Үйлчилгээний төрөл	2021 он		2022 он		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	
Мэдээлэл холбоо	Үүрэн холбоо	920.54	56.00%	1,039.76	<b>55.92%</b>	13.0%
	Суурин интернэт	152.29	9.26%	172.44	9.27%	13.2%
	Хот, хот хоорондын сүлжээ	127.15	7.74%	119.76	6.44%	-5.8%
	Улс хооронд, транзит сүлжээ	82.47	5.02%	83.57	4.49%	1.3%
	Сүлжээ, дэд бүтцийн угсралт, суурилуулалт	48.10	2.93%	82.83	4.45%	72.2%
	Суурин холбоо	25.28	1.54%	31.60	1.70%	25.0%
	Контентийн үйлчилгээ	11.23	0.68%	-	-	-
	Мэдээллийн сүлжээ	-	-	8.26	0.44%	-
	Сансрын холбоо	8.60	0.52%	8.09	0.44%	-5.9%
	Яриа - улс хооронд	2.10	0.13%	2.36	0.13%	12.2%
Өргөн нэвтрүүлэг	ОСДҮ - IPTV	91.34	5.56%	117.57	6.32%	28.7%
	ОСДҮ – Хиймэл дагуул, КаТВ	66.99	4.08%	63.69	3.43%	-4.9%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	44.33	2.70%	55.31	2.97%	24.8%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	25.37	1.54%	21.99	1.18%	-13.3%
	Арилжааны радио	2.16	0.13%	3.28	0.18%	51.5%
Шуудан	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	35.75	2.18%	48.86	2.63%	36.6%
<b>Нийт</b>		<b>1,643.7</b>	<b>100%</b>	<b>1,859.4</b>	<b>100%</b>	<b>13.1%</b>

### 3.2 Төсөвт төвлөрүүлсэн орлого

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого өсөхийн хэрээр төсөвт төвлөрүүлж буй орлого<sup>1</sup> өсч ирсэн ба 2022 онд 324.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

<sup>1</sup> Төсөвт төвлөрүүлсэн орлого гэдэгт Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэл, Нэмүү өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Гаалийн татвар, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон бусад татвар, хураамж хамаардаг.

Зураг 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, оноор



Хүснэгт 2. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, үйл ажиллагааны чиглэлээр (тэрбум төгрөг)

Салбар	Үйлчилгээний төрөл	2021 он		2022 он		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт ТТ орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт ТТ орлогод эзлэх %	
Мэдээлэл холбоо	Үүрэн холбоо	187.29	62.31%	189.53	58.41%	1.20%
	Суурин интернэт	10.78	3.59%	4.63	1.43%	-57.07%
	Хот, хот хоорондын сүлжээ	26.23	8.73%	21.88	6.74%	-16.59%
	Улс хооронд, транзит сүлжээ	4.13	1.37%	4.94	1.52%	19.62%
	Сүлжээ, дэд бүтцийн угсралт, суурилуулалт	5.40	1.80%	24.87	7.66%	360.34%
	Суурин холбоо	2.32	0.77%	0.51	0.16%	-78.14%
	Контентийн үйлчилгээ	3.14	1.05%			
	Мэдээллийн сүлжээ			5.25	1.62%	
	Сансрын холбоо	0.83	0.28%	0.94	0.29%	13.73%
	Яриа - улс хооронд	0.1	0.06%	0.04	0.01%	-80.14%
Өргөн нэвтрүүлэг	ОСДҮ - IPTV	26.88	8.94%	35.79	11.03%	33.12%
	ОСДҮ – Хиймэл дагуул, КаТВ	13.18	4.38%	13.01	4.01%	-1.24%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	8.22	2.74%	10.04	3.09%	22.10%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	3.83	1.27%	5.76	1.78%	50.55%
	Арилжааны радио	0.35	0.12%	0.60	0.18%	69.68%
Шуудан	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	7.79	2.59%	6.69	2.06%	-14.17%
<b>Нийт</b>		<b>300.56</b>	<b>100.00%</b>	<b>324.47</b>	<b>100.00%</b>	<b>7.96%</b>

### 3.3 Хөрөнгө оруулалт

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2020 онд буурсан бол сүүлийн 2 жилд өсч, 2022 онд нийт 366.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 66.4%-ийг үүрэн холбооны сүлжээ үйлчилгээнд, 11.6%-ийг харилцаа холбооны сүлжээ байгуулахад зориулсан байна.

Зураг 6. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оноор



Хүснэгт 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр (тэрбум төгрөг)

Салбар	Үйлчилгээний төрөл	2021 он		2022 он		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт ХО-д эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт ХО-д эзлэх %	
Мэдээлэл холбоо	Үүрэн холбоо	172.23	61.83%	243.60	66.41%	41.4%
	Хот, хот хоорондын сүлжээ	24.23	8.70%	42.78	11.66%	76.5%
	Суурин интернэт	22.78	8.18%	10.09	2.75%	-55.7%
	Сүлжээ, дэд бүтцийн угсралт, суурилуулалт	5.66	2.03%	6.90	1.88%	21.8%
	Улс хооронд, транзит сүлжээ	5.41	1.94%	6.07	1.66%	12.2%
	Суурин холбоо	0.95	0.34%	0.74	0.20%	-23.0%
Өргөн нэвтрүүлэг	ОСДҮ - IPTV	33.62	12.07%	23.11	6.30%	-31.3%
	ОСДҮ – Хиймэл дагуул, КаТВ	2.19	0.78%	2.79	0.76%	27.8%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	1.57	0.56%	7.47	2.04%	375.7%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	0.52	0.19%	11.77	3.21%	2160.6%
	Арилжааны радио	0.45	0.16%	0.61	0.16%	36.1%
Шуудан	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	6.72	2.41%	10.89	2.97%	41.4%
<b>Нийт</b>		<b>278.54</b>	<b>100%</b>	<b>366.82</b>	<b>100%</b>	

#### 4. Харилцаа холбооны сүлжээ

2022 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх чиглэлээр (шуудангийн сүлжээг оруулахгүйгээр) нийт 12 хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа эрхэлж байна. (хүснэгт 4)

Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх (цаашид сүлжээний гэх) тусгай зөвшөөрлийг 2022 онд улс хоорондын сүлжээ байгуулах хамрах хүрээнд 2, хот, хот хоорондын сүлжээ байгуулах хамрах хүрээнд 2, суурин газар сүлжээ байгуулах хамрах хүрээнд 1-ийг тус тус нэмж олгосон.

*Хүснэгт 4. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2022 он*

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Хот, хот хооронд, 10	Улс хооронд, 6	Улс хооронд-транзит, 4	Суурин газрын түгээх, 2
	Хамрах хүрээ	Монгол Улс	Монгол Улс	Монгол Улс	Монгол Улс
1	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК				
2	Мобиком нэтворкс ХХК				
3	Жемнэт ХХК				
4	МТ Нэтворкс ХХК				
5	Айрон товер ХХК (2022)				
6	Эс Ти Би Эс ХХК (2022)				
7	Скайнэтворкс ХХК				
8	Скайстрим ХХК				
9	Ийзи гөү рөүд ХХК (2022)				
10	Ондо нэтворк ХХК (2022)				
11	Юни трансмишн нэтворк ХХК				
12	Согно телеком ХХК (2022)				

Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэгчид зах зээлд дараах төрлийн бөөний үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

*Хүснэгт 5. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний төрлүүд*

Хот, хот хооронд	Улс хооронд/транзит
- Шилэн кабелийн шөрмөс түрээслүүлэх	- Интернэтийн бөөний урсгалын үйлчилгээ
- Тоон суваг түрээслүүлэх (Е1 суваг, дата суваг)	- Улс хоорондын транзит үйлчилгээ
- Худаг, сувагчлал түрээслүүлэх	- Улс хоорондын түрээсийн шугам

#### 4.1 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт

Сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2022 оны орлого 203.3 тэрбум байгаа нь өмнөх оноос 3 хувиар буурсан үзүүлэлт ба нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний орлогын 10.9 хувийг эзэлж байна. Үүний 41.1 хувийг нь улс хоорондын бөөний болон транзит сүлжээний үйлчилгээний орлого бүрдүүлж байна.

Зураг 7. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, оноор



Хот, хот хоорондын сүлжээний үйлчилгээний орлого өмнөх оноос 5.8 хувиар буурсан бол улс хооронд, транзит үйлчилгээний орлого 1.3 хувиар өсчээ.

Харин үндсэн сүлжээний хөрөнгө оруулалт нийт дүнгээр өмнөх оноос 65 орчим хувиар өссөн дүнтэй байна. 2021 онд 5 компани хөрөнгө оруулалт хийсэн бол 2022 онд 7 компани хөрөнгө оруулалт хийсэн нь өсөлтөд нөлөө үзүүлжээ. Нийт хөрөнгө оруулалтын 33 хувийг Скайнэтворкс ХХК, 27 хувийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК бүрдүүлсэн байна.

Хүснэгт 6. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	209,612,215	13%	203,326,978	11%	-3.00%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	30,357,096	10%	26,815,851	8%	-11.67%
Хөрөнгө оруулалт	29,644,094	6%	48,853,532	13%	64.80%

## 4.2 Харилцаа холбооны сүлжээний урт

Монгол улсын харилцаа холбооны үндсэн сүлжээ (улс, хот хоорондын сүлжээ) нь нийт 48,644 км дамжуулах сүлжээнээс бүрдэж байна. Сүлжээний уртыг тусгай зөвшөөрөл эзэмшигчээр хүснэгт 9-д харуулав.

*Хүснэгт 7. Харилцаа холбооны хот, хот хоорондын дамжуулах сүлжээний урт (км), оноор*

	Нэрс	2019 он	2020 он	2021 он	2022 он	Хот хооронд	Хот суурин газарт
1	Жемнэт ХХК	2,265	2,265	2,265	<b>2,265</b>	2,265	
2	Скайнэтворкс ХХК	10,880	11,960	12,195	<b>12,624</b>	10,200	2,424
3	Мобиком нэтворкс ХХК*	11,685	12,572	12,895	<b>13,064</b>	10,701*	2,363
4	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	18,869	19,239	19,548	<b>19,676</b>	19,549	127
5	МТ Нэтворкс ХХК	241	241	241	<b>723</b>	723	
6	Айрон товер ХХК	-	65	134	<b>134</b>	65	69
7	Эс ти би эс ХХК				<b>120</b>		120
8	Ондо нэтворкс ХХК				<b>40</b>		40
	<b>Нийт урт</b>	<b>43,940</b>	<b>46,342</b>	<b>47,278</b>	<b>48,644</b>	<b>41,237</b>	<b>7,407</b>

\* радио релэйний сүлжээний урт нэмэгдсэн

Харилцаа холбооны сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2022 онд хот хооронд **477** км, хот суурин газарт **184** км шилэн кабелийн сүлжээ шинээр байгуулсан байна.


*Хүснэгт 8. Шилэн кабелийн сүлжээний урт (км), 2022 он*

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Хот хооронд		Хот суурин газрын сүлжээний урт	Нийт
	Сүлжээ хүрсэн чиглэл/ аймгийн тоо	урт		
Жемнэт ХХК	Урд хилээс хойд хил хүртэл	2,265		2,265
Скайнэтворкс ХХК	21 аймаг, 110 сум	10,200	2,424	12,624
Мобиком нэтворкс ХХК	21 аймаг, 124 сум	7,891	577	8,468
Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	21 аймаг, 331 сум	19,549	127	19,676
МТ Нэтворкс ХХК	4 аймгийн 8 сум*	723		723
Айрон товер ХХК	2 аймгийн 4 сум**	65	69	134
Эс Ти Би Эс ХХК	УБ хот дотор		120	120
Ондо нэтворкс ХХК	УБ-Налайх		40	40
<b>Нийт урт</b>		<b>40,693</b>	<b>3,357</b>	<b>44,050</b>

\* МТ Нэтворкс ХХК: Дорнод (Чойбалсан – Хавиргын боомт), Говь-Алтай (Чандмань – Эрдэнэ), Сэлэнгэ (Сүхбаатар – Алтанбулаг хилийн боомт), Архангай аймгийн Цахир – Хөвсгөл аймгийн Жаргалант

\*\* Айрон товер ХХК: Сэлэнгэ (Ерөө-Бугант), Дорнод (Гурван загал - Дашбалбар)

Зураг 8. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил, 2022 он



Хот хоорондын шилэн кабелийн үндсэн сүлжээний 49.1 хувийг төрийн өмчийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн сүлжээ бүрдүүлж байгаа бол 24.8 хувийг Скайнэтворкс ХХК, 19.6 хувийг Мобиком нэтворкс ХХК-ийн байгуулсан сүлжээ тус тус бүрдүүлж байна.

#### 4.3 Улс хоорондын сүлжээний үйлчилгээ

Монгол Улсын хэмжээнд харилцаа холбооны улс хооронд болон транзит сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 компани БНХАУ, ОХУ, Хонгконг, АНУ, ХБНГУ, Япон улсын компаниудаар дамжуулан Ази, Европын үндсэн порттой шууд холбогдож, интернэтийн бөөний урсгалын үйлчилгээг үзүүлж байна.

Интернэтийн гадаад урсгалын нийт багтаамж жил бүр өсч байгаа бөгөөд 2022 онд 570.5 Гбит/сек-д хүрч, 2021 оноос 26.6 хувиар, 2019 оноос 3.6 дахин нэмэгдсэн байна. Үүнээс интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд түрээсэлж буй урсгалын хэмжээ 200.1 Гбит/сек-д хүрсэн нь өмнөх оноос 8.7 хувиар өссөн үзүүлэлт байна.

Зураг 9. Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчдийн нийт урсгалын багтаамж:  
Гбит/сек



2022 оны байдлаар нийт 51 интернэтийн үйлчилгээ эрхлэгч (ISP) улс хоорондын сүлжээ эзэмшигчдээс гадаад интернэтийн урсгал түрээслэж байна.

#### 4.4 Улс хоорондын транзит үйлчилгээ

Улс хооронд транзит урсгал түрээслүүлэх үйлчилгээг Жемнэт ХХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Мобиком нэтворкс ХХК-иуд үзүүлж, нийт 1700 Гбит/сек урсгалыг ОХУ, БНХАУ-ын харилцаа холбооны компаниудад түрээслүүлж байна.

Түрээслүүлж буй транзит урсгалын хэмжээ өмнөх оноос 24 хувиар, 2019 онтой харьцуулахад 2022 онд 2.3 дахин өсчээ.

Улс хоорондын транзит урсгал түрээслүүлэх үйлчилгээнээс 2022 онд 28.8 тэрбум төгрөгийн орлого орсон нь 2021 оноос 31 хувиар өссөн байна.

Хүснэгт 9. Улс хоорондын нийт транзит урсгал ба орлогын хэмжээ, оноор


Он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Урсгалын хэмжээ, Гбит/сек	750	770	1370	1700
Орлого Тэрбум төгрөг	17.3	18.4	22.0	28.8

#### 4.5 Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ

Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд 4 аж ахуйн нэгж, сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд 2 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж, сүлжээний түрээс, яриа, интернэтийн үйлчилгээ үзүүлж байна.

2022 онд нийт үйл ажиллагааны орлого 8.1 тэрбум байгаа нь өмнөх оноос 6 хувь орчмоор буурсан үзүүлэлттэй, нэмэлт хөрөнгө оруулалт энэ үйлчилгээнд хийгдээгүй байна. (Хүснэгт 10)

Зураг 10. Сансрын холбооны үйлчилгээний орлого, оноор /тэрбум төгрөг/



Хүснэгт 10. Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн орлого, сүүлийн 2 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	8.60	0.52%	8.09	0.44%	-5.9%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	0.83	0.28%	0.94	0.29%	13.73%

Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс Исатком ХХК нь тусгай зөвшөөрлийн гэрээний хүрээнд эцсийн хэрэглэгчид интернэт, ярианы үйлчилгээг үзүүлдэг бол бусад компаниуд нь зөвхөн сүлжээний үйлчилгээ үзүүлж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар сансрын холбооны үйлчилгээ авч буй Исатком ХХК-ийн 377 хэрэглэгч байгаа нь өмнөх оноос 16 хувиар буурсан байна. (хүснэгт 11)

Хүснэгт 11. Сансрын холбооны үйлчилгээний хэрэглэгчийн тоо

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	2020 он	2021 он	2022 он
1	Исатком ХХК	438	438	366

## 5. Үүрэн холбооны үйлчилгээ

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үүрэн холбооны яриа, мессеж болон интернэт үйлчилгээг 5 компани үзүүлж байна. Энэхүү зах зээл нь харилцаа холбооны хамгийн өрсөлдөөнт, хамгийн том зах зээл бөгөөд тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлогын 50 гаруй хувь, хөрөнгө оруулалтын 60 гаруй хувийг тус тус эзэлдэг.

Монгол Улс үүрэн холбооны үйлчилгээний 3G технологийг 2008 онд, 4G технологийг 2016 онд тус тус зах зээлд нэвтрүүлж байсан бол 2021 оноос 5G технологийн туршилтыг хийж эхлүүлээд байна.

Үүрэн холбооны нийт идэвхитэй хэрэглэгчийн тоогоор оператор компаниудын зах зээлд эзлэх хувийг тооцдог бөгөөд 2022 онд шинээр Ондо ХХК-ийн үзүүлэлт нэмэгдсэнээр бусад 4 компанийн зах зээлд эзлэх хувь бага зэрэг буурсан үзүүлэлттэй, ерөнхий харьцаа хэвээр хадгалагдаж байна. (хүснэгт 12)


*Хүснэгт 12. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь*

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Мобиком корпораци ХХК	38.64%	37.80%	38.03%	38.17%	38.30%	37.95%
Скайтел ХХК	15.25%	16.51%	17.43%	18.06%	17.65%	17.50%
Юнител ХХК	35.16%	34.03%	33.08%	32.20%	34.34%	34.04%
Жи-Мобайл ХХК	10.95%	11.66%	11.46%	11.58%	9.71%	9.66%
Ондо ХХК						0.85%

### 5.1 Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт

Үүрэн холбооны үйлчилгээний орлого 2015 оноос 2022 он хүртэл тогтмол өссөн бөгөөд дундаж өсөлт нь 11.41 хувь байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар үүрэн холбооны орлого 1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 12.95 хувиар өсчээ.

Зураг 11. Үүрэн холбооны нийт орлого /тэрбум.төг/



Хүснэгт 13. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	920.54	56.00%	1,039.76	<b>55.92%</b>	13.0%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	187.29	62.31%	189.53	58.41%	1.20%
Хөрөнгө оруулалт	172.23	61.83%	243.60	66.41%	41.4%


Арван таван жилийн өмнө үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлогын 90 орчим хувийг дангаар ярианы үйлчилгээ эзэлж байсан бол 2008 оноос хойш өндөр хурдны 3G үйлчилгээ, 2016 онд LTE үйлчилгээ нэвтэрснээс хойш хэрэглэгчийн хандлага ярианаас дата үйлчилгээ рүү шилжиж, жилээс жилд ярианы үйлчилгээний орлого буурч, дата үйлчилгээний орлого өсч байна. Хүснэгт 21-ээс харахад 2022 онд нийт орлогын 35.35 хувийг ярианы үйлчилгээ, 31.26 хувийг дата үйлчилгээ эзэлж байна. Дата үйлчилгээний орлогыг 2017 онтой харьцуулахад 4.0 дахин өссөн байна.

Хүснэгт 14. Үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлогын бүтэц

Орлогын бүтцээр	Орлогын бүтэц, %					
	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Яриа	47.70%	38.70%	37.55%	36.67%	34.29%	35.35%
Дата үйлчилгээ	14.90%	21.60%	25.00%	28.27%	32.35%	31.26%
Богино үсэгт мэдээ	5.54%	6.71%	4.10%	3.85%	3.35%	3.79%
Харилцан холболт	9.02%	7.89%	7.08%	7.20%	6.90%	6.15%
Дамжуулан холболт	0.58%	0.01%	0.01%	0.02%	0.02%	0.01%
Улс хоорондын үйлчилгээ	0.86%	1.25%	0.72%	0.49%	0.50%	0.53%
Нэмэлт үйлчилгээ	5.70%	4.32%	4.26%	5.01%	4.61%	3.96%
Улс хоорондын роуминг	1.09%	0.99%	1.10%	0.18%	0.12%	0.28%
Гар утас,модем	11.12%	12.42%	13.52%	11.06%	11.51%	11.97%
Бусад	3.50%	6.11%	6.65%	7.26%	6.35%	6.69%
НИЙТ	100.00%	100.00%	100.00%	100.00%	100.00%	100.00%


Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого 2022 онд өмнөх оноос 8.5 хувиар өссөн байна.

Зураг 12. Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/



Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо өсч, хамрах хүрээ тэлж, үйлчилгээ эрхлэгчид шинэ үйлчилгээ, шинэ технологийг эрэлхийлж жил бүр хөрөнгө оруулалтыг хийсээр байна. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид 2022 онд 243.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн нь өмнөх оноос 41.44 хувиар өссөн байна.


Зураг 13. Үүрэн холбооны хөрөнгө оруулалт төсөв төвлөрүүлсэн орлого /тэрбум төгрөг/



## 5.2 Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт үүрэн холбооны хэрэглэгчийн тоо нь давхардсан тоогоор 4.8 сая, 100 хүнд ногдох үзүүлэлтээр 141.8-д хүрлээ. (зураг 14) Энэ үзүүлэлт нь дэлхийн орнуудын дундажтай харьцуулахад Монгол Улсын хувьд харьцангуй өндөр үзүүлэлт юм. (хүснэгт 15)

Зураг 14. Үүрэн холбооны идэвхитэй хэрэглэгчийн тоо, оноор




Хүснэгт 15. Үүрэн холбооны нэвтрэлтийн түвшин

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Дэлхийн дундаж	97	101	103	105	106	105	106	108
Монгол улс	103.5	111.2	125.5	133.4	136.7	132.5	137.0	141.8

Эх сурвалж: ITU

Үүрэн холбооны нийт хэрэглэгчийн 67.9 хувийг урьдчилсан төлбөрт, 22.2 хувийг дараа төлбөрт, 9.9 хувийг хосолсон төлбөрт хэрэглэгч эзэлж байна. Жил ирэх бүр үүрэн холбооны хэрэглээ дараа болон хосолсон төлбөрт хэлбэр лүү шилжих хандлагатай байгаа нь зураг 15-аас харагдаж байна.

Зураг 15. Хэрэглэгчийн төлбөрийн нөхцөл



Үүрэн холбооны сүлжээнд 3.9 сая хэрэглэгч интернэт хэрэглэж байна. Тус хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн 9 хувийг дата (only data) хэрэглэгч эзэлж байгаа нь өмнөх жилээс 2 хувиар өсчээ.


Хүснэгт 16. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо

Он	Дата ба яриа хосолсон	Зөвхөн дата Only data	Нийт
2018	3,325,317	95,239	3,420,556
2019	3,351,665	252,686	3,604,351
2020	3,353,188	226,583	3,579,771
2021	3,633,268	255,971	3,889,239
<b>2022</b>	<b>3,644,821</b>	<b>352,079</b>	<b>3,996,900</b>

Үүрэн холбооны 3G сүлжээ Монгол Улсын 345 сум, суурин газарт нэвтэрч, нийт хүн амын 100 хувийг хамарсан бөгөөд хэрэглэгчийн тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 3.5 саяд хүрч, 2021 онтой харьцуулахад 0.57 хувийн өсөлттэй байна.

Харин 4G/LTE сүлжээ нийт хүн амын 99 хувийг хамарч, үйлчилгээний хэрэглэгчийн тоо 3 саяд хүрч, дата хэрэглээ жил ирэх тусам өсөж байна.

Зураг 16. 3G, 4G/LTE хэрэглэгчийн тоо. мян



Үүрэн холбооны сүлжээ жил ирэх бүр хүрээгээ тэлж, нийт бааз станцын 50 орчим хувийг 4G сүлжээний, 26.8 хувийг 3G сүлжээний, 23.6 хувийг 2G сүлжээний бааз станц бүрдүүлж байна.

Хүснэгт 17. Үүрэн холбооны нийт бааз станцын тоо, технологийн төрлөөр

	2G		3G		4G		Нийт	
	Тоо	Өсөлт	Тоо	Өсөлт	Тоо	Өсөлт	Тоо	Өсөлт
<b>2019</b>	2,031		2,225		2,454		6,710	
<b>2020</b>	2,480	22%	2,691	21%	3,656	49%	8,827	32%
<b>2021</b>	2,734	10%	2,980	11%	4,344	19%	10,058	14%
<b>2022</b>	2,753	1%	3,128	5%	5,769	33%	11,650	16%
		23.6%		26.8%		49.5%		100%


Үүрэн холбооны 4 оператор компани 2022 онд орон нутагт 448 бааз станц шинээр байгуулж, сүлжээг өргөжүүлсэн бөгөөд үүний 85 хувь нь 4G/LTE сүлжээнийх бол 15 хувь нь 3G сүлжээнийх байна.

Үүрэн холбооны нийт хэрэглэгч болон 3G, 4G/LTE хэрэглэгчийн тоог Улаанбаатар хот, аймаг, бүс нутгийн хүн амын тоотой харьцуулахад 4G/LTE хэрэглэгчийн нэвтрэлт баруун бүсэд хамгийн бага буюу 65.4 хувьтай байгаа бол Улаанбаатар хотод 105.6 хувьд хүрсэн ба үүнийг аймаг тус бүрээр дэлгэрэнгүй байдлаар хүснэгт 18-д, мөн зураг 17, 18, 19-д тус тус харуулав.


Хүснэгт 18. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо бүс, байршлаар

БАЙРШЛААР	ХҮН АМ	ҮҮРЭН ХОЛБОО	3G	4G/LTE
<b>АЙМАГ, ХОТ</b>	1,765,782	2,215,431	1,556,503	1,306,365
<b>НИЙТ</b>	3,457,548	4,835,520	3,559,582	3,093,665
		139.85%	102.95%	89.48%
<b>БАРУУН БҮС</b>	<b>418,707</b>	<b>496,994</b>	<b>303,295</b>	<b>273,936</b>
БАЯН-ӨЛГИЙ	114,776	115,331	68,769	68,888
ГОВЬ-АЛТАЙ	57,098	75,775	45,983	40,568
ЗАВХАН	71,798	96,855	57,716	44,004
УВС	83,964	100,504	62,557	57,043
ХОВД	91,071	108,529	68,270	63,433
<b>ХАНГАЙН БҮС</b>	<b>603,427</b>	<b>699,208</b>	<b>466,589</b>	<b>398,196</b>
АРХАНГАЙ	93,149	106,301	60,807	56,892
БАЯНХОНГОР	88,397	101,542	65,377	56,041
БУЛГАН	61,161	67,677	46,072	39,146
ОРХОН	109,125	122,957	99,084	87,251
ӨВӨРХАНГАЙ	114,962	124,998	90,813	70,230
ХӨВСГӨЛ	136,633	175,733	104,436	88,636
<b>ТӨВИЙН БҮС</b>	<b>515,771</b>	<b>714,728</b>	<b>577,032</b>	<b>476,232</b>
ГОВЬСҮМБЭР	18,007	21,517	17,303	14,441
ДАРХАН -УУЛ	107,932	128,055	100,026	89,454
ДОРНОГОВЬ	71,129	99,818	81,467	65,672
ДУНДГОВЬ	46,387	57,254	38,184	29,962
ӨМНӨГОВЬ	72,937	164,382	127,377	116,988
СЭЛЭНГЭ	107,341	124,409	105,643	86,799
ТӨВ	92,038	119,293	107,032	72,916
<b>ЗҮҮН БҮС</b>	<b>227,877</b>	<b>304,501</b>	<b>209,587</b>	<b>158,001</b>
ДОРНОД	83,704	102,530	74,469	61,132
СҮХБААТАР	65,214	83,587	53,912	43,064
ХЭНТИЙ	78,959	118,384	81,206	53,805
<b>УЛААНБААТАР</b>	<b>1,691,766</b>	<b>2,620,089</b>	<b>2,003,079</b>	<b>1,787,300</b>
		154.90%	118.4%	105.6%


Зураг 17. Үүрэн холбооны нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2022 он.



Зураг 18. Үүрэн холбооны 3G нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2022 он.




Зураг 19. Үүрэн холбооны 4G/LTE нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2022 он.



Үүрэн холбооны сүлжээн дэх M2M хэрэглэгчийн тоо 193,135 болж нэмэгдсэн нь өмнөх оноос 70% өссөн байна.


Зураг 20. M2M хэрэглэгчийн тоо




“M2M хэрэглэгч” гэж машин буюу төхөөрөмж хооронд (автомашины GPS, ТҮЦ машин, төлбөр тооцооны PoS машин, камер, ухаалаг тоолуур, гэрийн ухаалаг төхөөрөмжүүд гм), хүний оролцоогүйгээр өрөгдөл дамжуулах зорилгоор ашиглаж буй сим карт буюу хэрэглэгчийн тоо юм. M2M мобайл сүлжээ хэрэглэгч нь ямар нэг хувь хүнд хамаарахгүй, тухайн төхөөрөмжийг хэд хэдэн хүн ашиглах боломжтой байдгаараа онцлогтой.

Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 4,016,154-д хүрч өмнөх оноос 4.13 хувиар өссөн байна. Хэрэглэгчийн ухаалаг төхөөрөмжийн 71.1 хувийг Андроид, 26.6 хувийг Apple IOS үйлдлийн систем бүхий төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд Apple IOS төхөөрөмжийн хэрэглээ өмнөх оноос 26.5 хувиар өсчээ.

Зураг 21. Ухаалаг төхөөрөмжийн төрөл



Зураг 22. Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо




### 5.3 Үүрэн холбооны ачаалал/хэрэглээ

Үүрэн холбооны сүлжээ засаг захиргааны нэгж, сумын түвшинд 100 хувь нэвтэрч, сүлжээний хамрах хүрээг тэлж байгаатай холбоотой үүрэн холбооны ачааллын үзүүлэлтүүд нэмэгдсээр байна.

#### 5.3.1 Ярианы ачаалал

Үүрэн сүлжээ доторх ачааллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.51 хувиар, гарах ярианы ачаалал 1.92 хувиар тус тус буурсан, орох ачаалал 0.03 хувиар өссөн байна.

Зураг 23. Үүрэн холбооны сүлжээн дэх ярианы ачаалал, сая минут




Үүрэн холбооны ярианы ачааллын дийлэнх хувийг сүлжээнд доторх яриа эзэлдэг нь сүлжээндээ үнэгүй ярих үйлчилгээг оператор бүр үзүүлдэгтэй холбоотой юм. Гэхдээ бусад сүлжээнд ярих ачаалал сүүлийн жилүүдэд бага зэрэг өсөх хандлагатай байна.

Үүрэн сүлжээн дэх ярианы нийт ачааллыг хэрэглэгчийн тоотой харьцуулж тооцоолоход үүрэн холбооны нэг хэрэглэгч хоногт дунджаар 7 минут ярьж байгаа нь 5 жилийн өмнөхтэй харьцуулахад 1 минут орчмоор буурсан үзүүлэлт байна. Хэрэглэгчид улс хооронд болон дотоодод интернэтэд суурилсан аппликэйшн ашиглан үнэгүй ярьж байгаа нь ярианы ачаалал буурах хүчин зүйл болж байна.

### 5.3.2 Мессеж ба дата хэрэглээ

2022 оны жилийн эцсийн байдлаар үүрэн холбооны нэг хэрэглэгч сард дунджаар 14 ширхэг мессежийг илгээсэн бөгөөд нийт дүнгээрээ 2017 оны хэрэглээнээс 4.7 дахин буурсан байгаа нь хэрэглэгчид интернэт орчинд үнэгүй аппликэйшн ашиглаж байгаатай холбоотой гэж үзвэл харин эсрэгээр 4G сүлжээнд үүсгэсэн нэг хэрэглэгчийн дата хэрэглээ жил бүр өсөлттэй байгаа бөгөөд 2021 онд 10 Гбайт, 2022 онд 12.8 Гбайтад хүрсэн байна. Тухайн хэрэглээг нийт дүнгээр нь авч үзвэл 474,596 Терабайт хүрсэн нь 2020 оноос 1,7 дахин, 2021 оноос 1.3 дахин нэмэгджээ.


Зураг 24. Үүрэн холбооны хэрэглэгчдийн нэг сарын дундаж мессеж болон дата хэрэглээ



Үүрэн холбооны хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ 2022 жилийн эцсийн байдлаар 474,596 Терабайтад хүрч, дата хэрэглээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.10 хувиар өссөн байна.

Цаашид ярианы ачаалал нь дата өгөгдөл рүү шилжих хандлага ажиглагдаж байна. Зах зээлийн өрсөлдөөн, технологийн хөгжил дэвшил гар утасны хэрэглээ, түүнийг дагасан нэмэлт үйлчилгээ болон контентууд, OTT төрлийн үйлчилгээ нь хэрэглэгчийн тооны өсөлт, ашиг орлогод нөлөөлөхөөр байна.

Зураг 25. Үүрэн холбооны хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ /ТВ/



Хүснэгт 19. Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж дата хэрэглээ

ОН	3G хэрэглэгч	Дата хэрэглээ нийт /GB/	Нэг хэрэглэгчийн 1 сарын дундаж хэрэглээ /GB/	4G хэрэглэгч	Дата хэрэглээ нийт /GB/	Нэг хэрэглэгчийн 1 сарын дундаж хэрэглээ /GB/
2018	2,515,800	34,157,518	1.1	1,473,300	34,578,336	2
2019	3,190,500	43,010,021	1.1	1,956,800	102,903,673	4.4
2020	3,294,300	50,291,174	1.3	2,365,100	212,004,218	7.5
2021	3,539,362	48,883,129	1.2	2,809,592	356,579,612	10.58
2022	3,559,582	41,425,077	1.0	3,093,666	474,596,487	12.78

Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид LTE сүлжээнд смарт бокс ашигласан “Гэр”, “Манай”, “Скайнэт” зэрэг интернэт үйлчилгээг санал болгож буй бөгөөд тэдгээр хэрэглэгчийн тоо 2022 оны байдлаар 133,851 байгаа нь өмнөх оноос бага зэрэг буурсан байна. Энэ үйлчилгээ нь шилэн кабелийн сүлжээ хүрээгүй, үүрэн холбооны сүлжээний хамрах хүрээнд өрхийн интернэт үйлчилгээ авах боломжийг бүрдүүлдэг онцлогтой.

Хүснэгт 20. Хөдөлгөөнт өргөн зурвасын смарт бокс ашиглан үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо

	2018	2019	2020	2021	2022
Хөдөлгөөнт өргөн зурвас LTE/WiMax Смарт бокс хэрэглэгч	101,959	102,185	114,602	136,030	<b>133,851</b>

## 6. Суурин интернэт үйлчилгээ

Суурин интернэтийн үйлчилгээ эрхэлж буй 61 тусгай зөвшөөрөл эзэмшигч (ISP) байгаагаас 27 нь Монгол Улс, 16 нь Улаанбаатар, 18 нь аймаг сумын хамрах хүрээ бүхий тусгай зөвшөөрөлтэй байна. 2022 онд шинээр 3 интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 7 тусгай зөвшөөрлийг цуцалсан ба 2 тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон байна.

Идэвхитэй гэрээт хэрэглэгчийн тоогоор зах зээлд эзлэх хувийг нийт Монгол Улс, Улаанбаатар хот болон орон нутагт гэж тооцвол ТОП 6 компани нийт зах зээлийн 99 орчим хувийг дангаар бүрдүүлж байна. (хүснэгт 21)

АйПиТВ үйлчилгээ үзүүлэгч 2 компанийн эзлэх хувь өндөр байгаагаас харвал хэрэглэгч интернэтийг дангаар бус телевиз, контентийн үйлчилгээтэй хослуулан хэрэглэх хандлага өндөр байгааг илэрхийлж байна.

*Хүснэгт 21. Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхитэй хэрэглэгчийн тоогоор*

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Монгол Улс		Улаанбаатар		Орон нутаг	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Юнивишн ХХК	330,577	75.7%	239,669	74.9%	90,907	77.8%
2	Скаймедиа корпораци ХХК	50,556	11.6%	43,716	13.7%	6,840	5.9%
3	Мобинет ХХК	18,692	4.3%	12,120	3.8%	6,572	5.6%
4	Эн Би Си ХХК	7,601	1.7%	7,601	2.4%		0.0%
5	Монголын цахилгаан холбоо ХК	17,247	3.9%	7,066	2.2%	10,181	8.7%
6	Кевико ХХК	7,333	1.7%	6,814	2.1%	519	0.4%
	Нийт		<b>98.9%</b>		<b>99.1%</b>		<b>98.4%</b>

### 6.1 Суурин интернэт үйлчилгээний орлого


Суурин интернэт үйлчилгээний орлого 2022 онд өмнөх оноос 13 хувиар өсч 172.4 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт харилцаа холбооны үйлчилгээний орлогын 9.27 хувийг эзэлж байна. Төсөвт төвлөрүүлсэн орлого 4.6 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 2 дахин буурсан үзүүлэлт байна.

*Хүснэгт 22. Суурин интернэт үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт*

Үзүүлэлт	2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	152.29	9.26%	172.44	9.27%	13.2%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	10.78	3.59%	4.63	1.43%	-57.07%
Хөрөнгө оруулалт	22.78	8.18%	10.09	2.75%	-55.7%


2022 онд нийт 7 компани суурин интернэтийн үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийсэн нь 10 тэрбум орчим төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 55 хувиар буурчээ.

Зураг 26. Суурин интернэт үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/



Суурин интернэт үйлчилгээний нийт орлогын 51 хувь нь өрх, 8 хувь нь төсвийн байгууллага, 40 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчээс бүрдүүлж байна.

Зураг 27. Интернэтийн үйлчилгээний орлогын бүтэц



## 6.2 Суурин интернэт хэрэглэгчийн тоо

Монгол Улсын хэмжээнд суурин интернэтэд холбогдсон буюу гэрээт хэрэглэгчийн тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 56,720 -оор нэмэгдэн 436,447-д хүрч өмнөх оноос 15 хувиар өсчээ. Үүний 411,856 нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд нийт өрхийн 44% нь суурин интернэтэд холбогдсон нь өмнөх оноос 6.3 хувиар өсчээ. 100 хүнд ногдох үзүүлэлтээр тооцвол 12.6 хувьд хүрсэн байна.

Зураг 28. Суурин интернэт хэрэглэгчийн тоо



Суурин интернэт хэрэглэгчийг байршлаар нь авч үзвэл 73.3 хувь нь Улаанбаатар хотод, 26.7 хувь нь орон нутагт байна.


Нийт өрхийн тоотой харьцуулбал Улаанбаатар хотод суурин интернэтийн нэвтрэлт 77 хувь, харин орон нутагт 23 хувьтай байна.

Зураг 29. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, байршлаар




Суурин интернэт хэрэглэгчийн 93 хувь нь өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ, үлдсэн 7 хувь нь Wi-Fi, Wi-MAX, DSL -ийн холболттой байна. 2020 онд гэрээт интернэт хэрэглэгчийн тоо буурсан бол 2021, 2022 онуудад өсч, шилэн кабелиар холбогдсон хэрэглэгчийн тоо 2022 онд 48 хувиар нэмэгджээ.

Зураг 30. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр



Интернэт хэрэглээ өсөхийн хэрээр гэрээт хурд өсч байна. 2022 оны тоон мэдээллээр нийт хэрэглэгчийн 84 орчим хувь 10 Мбит/сек-ээс дээш хурдаар үйлчилгээ авч байна.

Зураг 31. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар



Нийт интернэтийн хэрэглэгчийн 94 хувь нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд өрхийн тоотой харьцуулбал нэвтрэлт 44 орчим хувь, Улаанбаатар хотод 70 хувь, аймгуудаас хамгийн өндөр нь Орхон аймаг 58 хувьтай, харин хамгийн бага нь Завхан аймаг 7.2 хувьтай байна.

Хүснэгт 23. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр

Аймаг, хот	Хэрэглэгчийн тоо			Өрхийн тоо*	Өрхийн нэвтрэлт
	Нийт	Байгууллагын	Өрхийн		
<b>НИЙТ</b>	<b>436,447</b>	<b>24,591</b>	<b>411,856</b>	<b>941,547</b>	<b>43.7%</b>
<b>УЛААНБААТАР</b>	319,780	18,520	301,260	431,000	69.9%
<b>БАРУУН БҮС</b>	16,502	1,128	15,374	110,046	14.0%
БАЯН-ӨЛГИЙ	3,287	250	3,037	25,952	11.7%
ГОВЬ-АЛТАЙ	3,166	212	2,954	16,520	17.9%
ЗАВХАН	1,727	176	1,551	21,668	7.2%
УВС	3,504	241	3,263	22,369	14.6%
ХОВД	4,818	249	4,569	23,537	19.4%
<b>ХАНГАЙН БҮС</b>	38,886	1,794	37,092	177,586	20.9%
АРХАНГАЙ	2,787	180	2,607	28,219	9.2%
БАЯНХОНГОР	5,712	258	5,454	26,737	20.4%
БУЛГАН	1,914	242	1,672	19,098	8.8%
ОРХОН	17,701	596	17,105	29,292	58.4%
ӨВӨРХАНГАЙ	3,725	271	3,454	34,436	10.0%
ХӨВСГӨЛ	7,047	247	6,800	39,804	17.1%
<b>ТӨВИЙН БҮС</b>	47,151	2,493	44,658	153,339	29.1%
ГОВЬСҮМБЭР	2,457	91	2,366	5,265	44.9%
ДАРХАН -УУЛ	14,974	565	14,409	29,503	48.8%
ДОРНОГОВЬ	7,881	393	7,488	21,265	35.2%
ДУНДГОВЬ	1,718	162	1,556	14,892	10.4%
ӨМНӨГОВЬ	8,407	561	7,846	23,712	33.1%
СЭЛЭНГЭ	8,058	377	7,681	29,966	25.6%
ТӨВ	3,656	344	3,312	28,736	11.5%
<b>ЗҮҮН БҮС</b>	14,131	761	13,370	69,576	19.2%
ДОРНОД	7,112	299	6,813	24,919	27.3%
СҮХБААТАР	3,122	174	2,948	19,131	15.4%
ХЭНТИЙ	3,897	288	3,609	25,526	14.1%

\*Эх сурвалж: 2022 оны байдлаар өрхийн тоог 1212.тн

### 6.3 Суурин интернэтийн хэрэглээ

Нийт суурин интернэт хэрэглэгчийн тоо болон нийт хэрэглээнд харьцуулалт хийхэд нэг хэрэглэгч дунджаар сард 150 Гбит/сек интернэт хэрэглэж байна.

Харин Аж ахуйн нэгжийн нийт орлого болон хэрэглэгчийн тооноос нэг аж ахуйн нэгж сард дунджаар 273 мянган төгрөгийн орлого бүрдүүлдэг бол, нэг өрх дунджаар 17,600 төгрөг, төсвийн байгууллага сард дунджаар 280 мянган төгрөгний дундаж орлого (ARPU) бүрдүүлж байна.

Хүснэгт 24. Суурин интернэт үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ

Огноо	Суурин интернэт хэрэглэгч	Дата хэрэглээ нийт /GB/	Нэг өрхийн сарын дундаж хэрэглээ /GB/
2018 ОН	306,150	205,564,414	56
2019 ОН	317,317	279,347,965	73.4
2020 ОН	307,166	529,136,120	143.6
2021 ОН	379,727	672,012,475	147.5
2022 ОН	436,447	787,179,980	150.3

## 7. Суурин телефон үйлчилгээ

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 7 аж ахуйн нэгж суурин холбооны ярианы үйлчилгээ үзүүлж байна.

Суурин телефон үйлчилгээг Монголын цахилгаан холбоо ХК, УБТЗ ХНН-с гадна интернэт протоколд суурилсан технологи ашиглан АйПиТВ болон зарим интернэт үйлчилгээ эрхлэгчид үзүүлж байсан бол 2020 оноос шинэ үйлчлэгчид зах зээлд нэвтэрч, аппликэйшн суурьтай шинэ үйлчилгээнүүдээр зах зээлийг тэлж байна.

Суурин телефон үйлчилгээний идэвхитэй хэрэглэгчийн тоог ОУЦХБ-ын аргачлалын дагуу сүүлийн 3 сард төлбөр төлсөн хэрэглэгчээр тооцож, зах зээлд эзлэх хувийг Монгол Улс, Улаанбаатар болон орон нутаг гэсэн хамрах хүрээнд тодорхойлбол Юнивишн ХХК эдгээр хамрах хүрээнд 60-аас дээш хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 25. Суурин телефон үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхитэй хэрэглэгчийн тоогоор

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Монгол Улс		Улаанбаатар		Орон нутаг	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Монголын цахилгаан холбоо ХК	41,953	8.8%	27,912	7.02%	14,041	18.11%
2	УБТЗ ХНН	4,750	1.0%	2,335	0.59%	2,415	3.12%
3	Юнивишн ХХК	315,370	66.4%	266,176*	66.92%	49,194*	63.46%
4	Скаймедиа корпораци ХХК	49,618	10.4%	42,287	10.63%	7,331	9.46%
5	Мобинет ХХК	17,477	3.7%	12,936	3.25%	4,541	5.86%
6	Жи Мобайлнэт ХХК	5,516	1.2%	5,516	1.39%		0.00%
7	Онлайн нетворк ХХК	40,606	8.5%	40,606	10.21%		0.00%
	<b>Нийт</b>	<b>475,290</b>	<b>100%</b>	<b>397,768</b>	<b>100%</b>	<b>77,522</b>	<b>100%</b>

\* тооцоолсноор

Юнивишн болон Скаймедиа үйлчилгээний хэрэглэгчдийн хувьд дийлэнх хувь нь гурвалсан үйлчилгээний хэрэглэгчид эзэлж байгаа бөгөөд гурвалсан үйлчилгээний хүрээнд төлбөр төлснөөр ярианы үйлчилгээний хэрэглэгчээр тоологдож байгааг онцлох нь зүйтэй.


### 7.1 Суурин телефон үйлчилгээний орлого

Суурин телефон үйлчилгээний орлого 2022 онд өмнөх оноос 25 хувиар нэмэгдэж, 31.6 тэрбум төгрөг байгаа нь нийт орлогын 1.7 хувийг эзэлж байна. Харин төсөвт төвлөрүүлсэн орлого, хөрөнгө оруулалтын хэмжээ буурчээ.

*Хүснэгт 26. Суурин телефон үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт*


Үзүүлэлт	2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	25.28	1.54%	31.60	1.70%	25.0%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	2.32	0.77%	0.51	0.16%	-78.14%
Хөрөнгө оруулалт	0.95	0.34%	0.74	0.20%	-23.0%

*Зураг 32. Суурин телефон үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/*




Суурин холбооны нэг хэрэглэгчээс нэг сард олох дундаж орлого 2022 онд 5,540 төгрөг байгаа нь өмнөх оноос 5 хувиар өссөн байна.

Зураг 33. Суурин телефон үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/



Суурин телефон холбооны орлогын бүтцээс харахад нийт орлогын 91 хувь нь ярианы орлого, 8 хувь нь харилцан холболтын орлого, 1 хувь нь нэмэлт үйлчилгээнээс олсон орлого байна.


Зураг 34. Суурин телефон холбооны орлогын бүтэц 2022 он



## 7.2 Суурин телефон хэрэглэгчийн тоо

Суурин телефон үйлчилгээний 475,290 хэрэглэгч байгаагаас 77 хувь нь АйПиТВ хосолсон үйлчилгээний хэрэглэгч байна. Сүлжээнд сүүлийн 3 сар ярианы ачаалал үүсгэсэн (дугаар дээрээс яриа хийсэн эсхүл хүлээн авсан) байдлаар авч үзвэл 190,305 хэрэглэгч өөрийн суурин холбооны үйлчилгээний дугаараа сүлжээнд идэвхитэй ашиглаж байна.

Зураг 35. Суурин холбооны идэвхитэй хэрэглэгчийн тоо



Хосолсон үйлчилгээний хэрэглэгчид хэдийгээр суурин телефон үйлчилгээний сүлжээнд холбогдож, үйлчилгээ авах боломж бүрдэж байгаа ч хэрэглээ бага, дунджаар 10 орчим хувь нь идэвхитэй ачаалал үүсгэж байна.

Нийт суурин телефон хэрэглэгчийн 90 орчим хувь нь өрхийн, 10 хувь нь байгууллагын хэрэглэгч байна. Өрхийн хэрэглэгчдийн 84.6 хувь нь АйПитВ үйлчилгээндээ ярианы үйлчилгээ авч буй бол эсрэгээр байгууллагын хэрэглэгчдийн 90.8 хувь нь бусад суурин холбооны үйлчилгээ эрхлэгчдээс үйлчилгээ авч байна.

Хүснэгт 27. Суурин телефон хэрэглэгчийн тоо, хэрэглэгчийн төрлөөр

	Өрх		Байгууллага		Нийт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
<b>Нийт хэрэглэгчийн тоо</b>	<b>426,156</b>	<b>100%</b>	<b>49,134</b>	<b>100%</b>	<b>475,290</b>	<b>100%</b>
<b>IPTV үйлчилгээний хүрээнд</b>	360,464	84.6%	4,524	9.2%	364,988	76.8%
<b>Бусад</b>	65,692	15.4%	44,610	90.8%	110,302	23.2%

Суурин телефон хэрэглэгчийн 83.7 хувь нь Улаанбаатар, 16.3 хувь нь орон нутгийн хэрэглэгч байна.

Хүснэгт 28. Суурин телефон хэрэглэгчийн тоо, байршлаар

	Улаанбаатар	Орон нутаг	Нийт
<b>Хэрэглэгчийн тоо</b>	<b>397,768</b>	<b>77,522</b>	<b>475,290</b>
<b>Эзлэх хувь</b>	83.7%	16.3%	100%

### 7.3 Суурин телефон үйлчилгээний ачаалал


Үүрэн холбоо, интернэт, гар утасны хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор суурин холбооны ярианы ачаалал жил бүр буурч байгаа билээ. 2020, 2021 онд бага зэрэг өссөн нийт ачаалал 2022 онд 45 хувь орчмоор буурчээ.

Суурин телефон сүлжээн доторх ачаалал 2022 онд 13.3 сая минут болж, 40 хувиар, гарах ярианы ачаалал 67.5 сая минут болж 50 хувиар, орох ярианы ачаалал 79 сая минут болж 41 хувиар тус тус буурсан байна.

Суурин сүлжээнээс гарах ачаалал орох ачааллаас байнга их байдаг уламжлалт хандлага 2021 онд бараг тэнцсэн бол 2022 онд эсрэг болж, суурин сүлжээ руу орох ачаалал нь гарах ачааллаас илүү болж, хэрэглээний хандлагад өөрчлөлт гарч байна.

Суурин холбооны ачааллын тоо хэмжээг хэрэглэгчийн тоонд харьцуулбал нэг хэрэглэгч хоногт дунджаар 2.7 минутын ярианы ачаалал үүсгэсэн байна.

Зураг 36. Суурин холбооны ярианы ачаалал /сая минут/



## 8. Олон суваг дамжуулах үйлчилгээ

Нийт 31 тусгай зөвшөөрөл эзэмшигч хиймэл дагуул, АйПиТВ, утасгүй газрын сүлжээ, кабель, интернэтэд суурилсан буюу ОТТ технологи ашиглан телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг зах зээлд үзүүлж байна.

Идэвхитэй хэрэглэгчийн тоогоор зах зээлд эзлэх хувийг нийт Монгол Улс, Улаанбаатар хот болон орон нутагт гэж тооцвол 8 компани нийт зах зээлийн 97 хувийг бүрдүүлж байна. (хүснэгт 29)

*Хүснэгт 29. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхитэй хэрэглэгчийн тоогоор*

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Монгол Улс		Улаанбаатар		Орон нутаг	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Юнивишн ХХК	322,376	42.4%	232,257	54.7%	90,119	26.9%
2	ДДэш ТВ ХХК	288,051	37.9%	92,963	21.9%	195,088	58.2%
3	Скаймедиа ХХК	50,433	6.6%	43,644	10.3%	6,789	2.0%
4	Эн Би Си ХХК	32,153	4.2%	32,153	7.6%	-	0.0%
5	Монголсат нэтворкс ХХК	24,229	3.2%	7,059	1.7%	17,170	5.1%
6	Монголын цахилгаан холбоо ХК	8,575	1.1%	1,093	0.3%	7,482	2.2%
7	Шинэ сансар кабель	7,949	1.0%	7949	1.9%	-	0.0%
8	Сансар Дижитал ХХК	6,192	0.8%	6,192	1.5%	-	0.0%
	Нийт		97.4%		99.6%		94.5%

\* Үүнд ОТТ үйлчилгээний хэрэглэгчийн тоог тооцоогүй болно.

### 8.1 Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого

Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого 2022 онд өмнөх оноос 14.5 хувиар өсч 181.3 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт харилцаа холбооны үйлчилгээний орлогын 9.75 хувийг эзэлж байна. Төсөвт төвлөрүүлсэн орлого 48.8 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 21.8 хувиар өсчээ.


Орлогын өсөлтөд АйПиТВ үйлчилгээний орлогын өсөлт нөлөө үзүүлсэн ба бусад олон суваг дамжуулах үйлчилгээний орлого 5 хувь орчмоор буурсан байна.

2022 онд нийт олон суваг дамжуулах үйлчилгээнд 25.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт оруулсны 89.2 хувийг АйПиТВ үйлчилгээнд оруулжээ. Нийт хөрөнгө оруулалт өмнөх оноос 27.7 хувиар буурсан байна.


Хүснэгт 30. Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт		2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	<b>Нийт</b>	<b>158.33</b>	<b>9.64%</b>	<b>181.26</b>	<b>9.75%</b>	<b>14.48%</b>
	IPTV	91.34	5.56%	117.57	6.32%	28.7%
	Хиймэл дагуул, КаТВ	66.99	4.08%	63.69	3.43%	-4.9%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	<b>Нийт</b>	<b>40.06</b>	<b>13.32%</b>	<b>48.8</b>	<b>15.04%</b>	<b>21.82%</b>
	IPTV	26.88	8.94%	35.79	11.03%	33.12%
	Хиймэл дагуул, КаТВ	13.18	4.38%	13.01	4.01%	-1.24%
Хөрөнгө оруулалт	<b>Нийт</b>	<b>35.81</b>	<b>12.85%</b>	<b>25.9</b>	<b>7.06%</b>	<b>-27.67%</b>
	IPTV	33.62	12.07%	23.11	6.30%	-31.3%
	Хиймэл дагуул, КаТВ	2.19	0.78%	2.79	0.76%	27.8%

Зураг 37. Олон суваг дамжуулах үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/




Зураг 38. Олон суваг дамжуулах үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төгрөг/



## 8.2 Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхитэй хэрэглэгч 2022 онд 760,028 болж өмнөх оноос 6 хувиар буурсан. Хэрэглэгчийн тоог технологийн төрлөөр авч үзвэл АйПиТВ хэрэглэгчийн тоо өсч, бусад технологийн хувьд буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 39. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхитэй хэрэглэгчийн тоо



\* Үүнд РТТС болон ОТТ үйлчилгээний хэрэглэгчийн тоо ороогүй болно.


Нийт хэрэглэгчийн 99.1 хувь нь өрхийн хэрэглэгч ба Монгол Улсын нийт өрхийн тоотой харьцуулбал 81 хувь нь телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг хүлээн авч үзэж байна.

Зураг 40. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршлаар




Зураг 41. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршил ба технологиор

Улаанбаатарт




Орон нутагт



Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг технологиор нь авч үзвэл хэрэглэгчийн 49.1 хувь нь АйПиТВ-ээр, 41.1 хувь нь хиймэл дагуулаар, 9.9 хувь нь кабелийн телевизээр үйлчилгээг хүлээн авч үзэж байна. 2022 оноос нийт хэрэглэгчийн сонгож буй технологид АйПиТВ-ийн эзлэх хувь давамгайлж эхэлж байна. Гэхдээ орон нутгийн хувьд хиймэл дагуулын сонголт давамгайлсан хэвээр байна.


Зураг 42. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгч, технологийн төрлөөр



Хиймэл дагуулын хэрэглэгчийн тоо буурахад МонголСат нэтворкс ХХК-ийн үйлчилгээний шинэчлэл нөлөө үзүүлсэн байна.

АйПиТВ үйлчилгээний хэрэглэгч 2022 онд 372,809 болж 16 хувиар өссөн ба үүнээс 97 хувь нь гурвалсан үйлчилгээний хэрэглэгч байна. Орон нутаг дахь АйПиТВ үйлчилгээний хэрэглэгчийн тоо өмнөх оноос 20 хувиар нэмэгджээ.

Зураг 43. АйПуТВ үйлчилгээний нийт хэрэглэгчийн тоо, оноор



Хүснэгт 31. АйПуТВ үйлчилгээний хэрэглэгчийн тоо, төрлөөр

Он	IPTV	IPTV+VOIP	IPTV+VOIP+INTERNET	IPTV+VOIP+INTERNET+WiMax/Mobile	НИЙТ
2018 он	14,873	2,666	218,855	0	236,394
2019 он	20,153	2,859	226,595	1,249	250,856
2020 он	7,063	426	252,345	1,056	260,890
2021 он	6,796	2,564	310,683	1,689	321,732
2022 он	8,806	1,420	360,076	2,507	372,809

Зураг 44. АйПуТВ хэрэглэгчийн тоо, байршлаар



Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоог өрхийн тоотой харьцуулбал нэвтрэлт 80.7 орчим хувь, Улаанбаатар хотод 98.6 хувь, аймгуудаас хамгийн өндөр нь Орхон аймаг 101.8 хувьтай, харин хамгийн бага нь Баян-Өлгий аймаг 39.6 хувьтай байна.

Хүснэгт 32. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр

Аймаг, хот	Идэвхитэй хэрэглэгчийн тоо	Өрхийн тоо*	Өрхийн нэвтрэлт
<b>НИЙТ</b>	<b>760,028</b>	<b>941,547</b>	<b>80.7%</b>
<b>УЛААНБААТАР</b>	<b>424,925</b>	<b>431,000</b>	<b>98.6%</b>
<b>БАРУУН БҮС</b>	<b>66,767</b>	<b>110,046</b>	<b>60.7%</b>
БАЯН-ӨЛГИЙ	10,277	25,952	39.6%
ГОВЬ-АЛТАЙ	9,065	16,520	54.9%
ЗАВХАН	11,962	21,668	55.2%
УВС	12,581	22,369	56.2%
ХОВД	22,882	23,537	97.2%
<b>ХАНГАЙН БҮС</b>	<b>116,235</b>	<b>177,586</b>	<b>65.5%</b>
АРХАНГАЙ	15,546	28,219	55.1%
БАЯНХОНГОР	15,174	26,737	56.8%
БУЛГАН	10,688	19,098	56.0%
ОРХОН	29,830	29,292	101.8%
ӨВӨРХАНГАЙ	21,034	34,436	61.1%
ХӨВСГӨЛ	23,963	39,804	60.2%
<b>ТӨВИЙН БҮС</b>	<b>107,025</b>	<b>153,339</b>	<b>69.8%</b>
ГОВЬСҮМБЭР	4,066	5,265	77.2%
ДАРХАН -УУЛ	21,641	29,503	73.4%
ДОРНОГОВЬ	15,886	21,265	74.7%
ДУНДГОВЬ	8,607	14,892	57.8%
ӨМНӨГОВЬ	17,656	23,712	74.5%
СЭЛЭНГЭ	20,567	29,966	68.6%
ТӨВ	18,602	28,736	64.7%
<b>ЗҮҮН БҮС</b>	<b>45,076</b>	<b>69,576</b>	<b>64.8%</b>
ДОРНОД	18,075	24,919	72.5%
СҮХБААТАР	12,353	19,131	64.6%
ХЭНТИЙ	14,648	25,526	57.4%

\*Эх сурвалж: 2022 оны байдлаар өрхийн тоог 1212.тн

## 9. Телевизийн үйлчилгээ

Телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хүрээнд улсын хэмжээнд нийт 145 телевиз ажиллаж байна. Үүнээс 50 нь орон нутагт буюу тухайн аймаг, суманд хамрах хүрээтэй телевизүүд байна.

2022 онд орон нутгийн 4, арилжааны 1 телевизийн тусгай зөвшөөрлийг цуцалсан ба төлбөртэй телевизийн үйлчилгээнд 5 тусгай зөвшөөрөл олгосон.


*Хүснэгт 33. Телевизийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр*

Хамрах хүрээ	Олон нийтийн	Өргөн нэвтрүүлгийн	Арилжааны	Төлбөртэй	Нийт
Улаанбаатар/ Монгол Улс	5	18	56	16	95
Орон нутагт		47	3		50
<b>Нийт</b>	<b>5</b>	<b>65</b>	<b>59</b>	<b>16</b>	<b>145</b>

Телевизийн үйлчилгээний нийт орлого (олон нийтийн телевизийг оруулахгүйгээр) 2022 онд 77.3 тэрбум байгаа нь өмнөх оноос 10.9 хувиар өсчээ. Энэ өсөлтөд өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн орлого нөлөө үзүүлж байгаа бөгөөд нийт орлогын 71.5 хувийг эзэлж байна. Арилжааны болон төлбөртэй телевизүүдийн орлого 13.3 хувиар буурсан ч төсөвт төвлөрүүлсэн орлого нь 50 хувиар нэмэгдсэн байна. (хүснэгт 34)

Телевизүүд 2022 онд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн бөгөөд үүнд төлбөртэй телевизийн хөрөнгө оруулалт голлох хувийг эзэлж байгаа юм.

*Зураг 45. Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн орлого /тэрбум төгрөг/*



*Хүснэгт 34. Телевизийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт*

Үзүүлэлт		2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	<b>Нийт</b>	<b>69.70</b>	<b>4.24%</b>	<b>77.30</b>	<b>4.15%</b>	<b>10.90%</b>
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	44.33	2.70%	55.31	2.97%	24.8%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	25.37	1.54%	21.99	1.18%	-13.3%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	<b>Нийт</b>	<b>12.05</b>	<b>4.01%</b>	<b>15.80</b>	<b>4.87%</b>	<b>31.12%</b>
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	8.22	2.74%	10.04	3.09%	22.10%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	3.83	1.27%	5.76	1.78%	50.55%
Хөрөнгө оруулалт	<b>Нийт</b>	<b>2.09</b>	<b>0.75%</b>	<b>19.24</b>	<b>5.25%</b>	<b>820.57%</b>
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	1.57	0.56%	7.47	2.04%	375.7%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	0.52	0.19%	11.77	3.21%	2160.6%

Нийт телевизийн үйлчилгээний орлогын 73.5 хувийг өргөн нэвтрүүлгийн телевизүүд, түүн дотроо УБ хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүд нийт орлогын 71 орчим хувийг бүрдүүлж байна. Харин орон нутгийн телевизүүдийн орлого нийт орлогод 2.2 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 35. Телевизийн үйлчилгээний 2022 оны орлого /Тэрбум төгрөг/*

	Өргөн нэвтрүүлгийн ТВ	Арилжааны ТВ	Нийт	%
<b>Улаанбаатар/ Монгол Улс</b>	53.72	21.92	<b>75.64</b>	97.85%
<b>Орон нутгийн</b>	1.59	0.06	<b>1.66</b>	2.15%
<b>Нийт</b>	55.31	21.99	<b>77.30</b>	100%
<b>%</b>	71.55%	28.45%	100%	

Телевизүүд 2022 онд зар сурталчилгаанаас 33.5 тэрбум төгрөгийн орлого олсон нь нийт орлогын 44.6 хувийг эзэлж байна. Зар сурталчилгааны орлогын 56 хувийг буюу 18.7 тэрбумын орлогыг Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизүүд бүрдүүлсэн бол 43 хувийг нь буюу 14.4 тэрбумыг Улаанбаатар хотын арилжааны телевизүүд, үлдсэн нэг хувийг орон нутгийн телевизүүд бүрдүүлж байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизүүд 2021 оноос олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс “өргөн нэвтрүүлгийн телевизийн хөлс” авч эхэлсэн бөгөөд уг орлого нь нийт орлогынх нь 25 орчим буюу багагүй хувийг эзэлж байна. Харин арилжааны

телевизүүдийн орлогын гол эх үүсвэр нь зар сурталчилгаа, орон нутгийн телевизүүдийн хувьд төлбөрт, захиалгат нэвтрүүлэг нэлээд хувь эзэлж байгааг хүснэгт 36-с харж болно.

Хүснэгт 36. Телевизийн үйлчилгээний 2022 оны орлогын бүтэц

Орлогын бүтэц	Өргөн нэвтрүүлгийн ТВ 55.31 тэрбум ₮		Арилжааны ТВ 19.91 тэрбум ₮		Нийт 75.21 тэрбум ₮
	Улаанбаатар 53.72 тэрбум ₮	Орон нутаг 1.59 тэрбум ₮	Улаанбаатар 21.92 тэрбум ₮	Орон нутаг* 0.06 тэрбум ₮	
Зар сурталчилгаа, үгэн зар	34.9%	22.3%	72.7%	4.2%	44.6%
Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ	2.3%	13.4%	2.6%	17.4%	2.6%
Ивээн тэтгэлт, бүтээгдэхүүн байршуулалт	16.8%	3.5%	2.0%	3.5%	12.6%
ӨНТВ-ийн үйлчилгээний хөлс	24.8%	2.8%	0.0%	0.0%	17.8%
Өөрийн бүтээл борлуулалт	4.6%	7.2%	6.8%	0.8%	5.2%
Теле худалдааны нэвтрүүлэг	0.0%	0.4%	6.9%	0.0%	1.8%
Төлбөрт, захиалгат, бусад нэвтрүүлэг	9.2%	23.5%	5.8%	64.1%	8.7%
Цаг үеийн мэдээ	0.2%	5.6%	0.1%	8.0%	0.3%
Бусад	7.1%	21.2%	3.2%	1.9%	6.4%
<b>Нийт</b>	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

\*Орон нутагт нийт 3 арилжааны ТВ үйл ажиллагаа эрхэлж байна.

## 10. Радиогийн үйлчилгээ

Монгол Улсын хэмжээнд нийт 62 радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаагаас 4 нь олон нийтийн, 58 нь арилжааны FM радио байна. Арилжааны FM радиогийн 34 нь Улаанбаатар хотод байршилтай ба үүнээс 4 нь Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэйгээр, хиймэл дагуул болон FM радио давтамж ашиглан нэвтрүүлгээ орон даяар дамжуулж байна. Нийт 12 аймагт орон нутгийн 24 FM радио ажиллаж байна.


2022 онд Зохицуулах хорооноос Архангай, Хөвсгөл, Говь-Алтай аймгуудад тус бүр нэг, нийт 3 FM радиогийн зөвшөөрөл олгосон бол нэг зөвшөөрлийг цуцалж, 3 зөвшөөрлийн хугацаа дуусгавар болжээ.

*Хүснэгт 37. Радиогийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр*

Хамрах хүрээ	Олон нийтийн радио	Арилжааны радио (FM)	Нийт
Монгол Улс	4	4	8
Улаанбаатар		30	30
Орон нутагт		24	24
Нийт	4	58	62

Радиогийн үйлчилгээний орлого 2021 онд 44.4 хувиар өссөн бол 2022 онд 51.5 хувь өссөн сайн үзүүлэлттэй байна. Төсөвт төвлөрүүлсэн орлого, хөрөнгө оруулалтын хэмжээ мөн 2022 онд өсчээ.

*Зураг 46. Радиогийн үйлчилгээний орлого /сая төгрөг/*



*Хүснэгт 38. Радиогийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт*

Үзүүлэлт	2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	2.16	0.13%	3.27	0.18%	51.5%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	0.35	0.12%	0.60	0.18%	69.68%
Хөрөнгө оруулалт	0.45	0.16%	0.61	0.16%	36.1%

Радиогийн үйлчилгээний орлогын 93.8 хувийг Улаанбаатар хотын радиогийн орлого бүрдүүлж байна. (хүснэгт 39)

Радиогийн орлогын бүтэц Улаанбаатар, орон нутгийн радиогийн хувьд харилцан ялгаатай бөгөөд Улаанбаатар хотын радиогийн орлогод ивээн тэтгэлт хамгийн өндөр 37.9 хувь, дараа нь зар сурталчилгаа, үгэн зар 33.2 хувийг эзэлж байгаагаас үзвэл зар сурталчилгаанаас орлого олох уламжлалт хандлагад тодорхой өөрчлөлт гарч буйг харуулж байна. Харин орон нутгийн радионуудын хувьд зар сурталчилгаа, үгэн зар голлох орлогыг бүрдүүлж байна. (хүснэгт 40)

*Хүснэгт 39. Радиогийн үйлчилгээний 2022 оны орлого, байршлаар*

Улаанбаатар	Орон нутаг	Нийт
<b>3.06</b>	<b>0.20</b>	<b>3.27</b>
<b>93.8%</b>	<b>6.2%</b>	<b>100%</b>

*Хүснэгт 40. Радиогийн үйлчилгээний орлогын бүтэц, 2022 он*

Орлогын бүтэц	Улаанбаатар	Орон нутаг	Нийт
Зар сурталчилгаа, үгэн зар	33.21%	91.78%	36.81%
Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ	3.73%	1.75%	3.60%
Ивээн тэтгэлт	37.88%	0.00%	35.55%
Өөрийн бүтээл борлуулалт	4.05%	1.64%	3.90%
Төлбөрт, захиалгат, бусад нэвтрүүлэг	8.23%	2.74%	7.89%
Бусад	11.07%	1.54%	10.48%
<b>Нийт</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>

## 11. Шуудангийн үйлчилгээ

2022 оны жилийн эцсийн байдлаар шуудангийн үйл ажиллагаа эрхлэх нийт 163 тусгай зөвшөөрлийг Зохицуулах хорооноос олгоод байна. Хүснэгт 41-д шуудангийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр тусгай зөвшөөрөл болон эзэмшигчийн тоог харуулав.

2022 онд шуудангийн сүлжээ байгуулах 5, шуудангийн үйлчилгээ эрхлэх 47, нийт 52 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон бол 11 тусгай зөвшөөрлийг цуцалжээ.

*Хүснэгт 41. Шуудангийн тусгай зөвшөөрлийн тоо*

№	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2022 онд шинээр олгосон
1	Шуудангийн сүлжээ байгуулах	13	9	5
2	Үндсэн үйлчилгээ	8	8	4
3	Буухиа шуудангийн үйлчилгээ	8	8	
4	Улс хоорондын логистикийн үйлчилгээ	16	16	10
5	Улс хоорондын илгээлтийн үйлчилгээ	79	65	27
6	Захиалгат болон нэмэлт үйлчилгээ	39	39	6
<b>НИЙТ</b>		<b>163</b>	<b>145</b>	<b>52</b>

Сүүлийн жилүүдэд цахим худалдаа, үйлчилгээ хөгжиж байгаатай холбоотойгоор улс хоорондын логистик, илгээлт болон дотоодын шуудангийн захиалгат, нэмэлт буюу хүргэлтийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо сүүлийн 2-3 жилд нэмэгдэж байна. Гэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тал орчим хувь нь л зах зээлд идэвхитэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд шуудангийн сүлжээ байгуулах эрх бүхий, тусгай зөвшөөрөлтэй 9 аж ахуйн нэгж байгаагаас 7 нь хот хооронд, 4 нь хотын дотор, 2 нь улс хооронд сүлжээ байгуулах эрхтэй бөгөөд тэдгээрээс 5 нь дотоодод шуудангийн үндсэн үйлчилгээ үзүүлэх эрхийг мөн эзэмшиж байна.

*Хүснэгт 42. Шуудангийн сүлжээ болон үндсэн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2022 он*

№	Шуудангийн сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигч	Хот хооронд 7	Хотын дотор 4	Улс хооронд 2	Үндсэн үйлчилгээ 8
1	Монгол Шуудан ХК				
2	Түгээмэл шуурхай шуудан ХХК				
3	Амар экспресс ХХК (2022)				
4	Ашид шуудан ХХК (2022)				

5	Мон тээвэр сервис				
6	Монгол инфинити шуудан ХХК				
7	Эйр март ХХК				
8	Эрчист гүрэн ХХК				
9	Ти Юу Хүргэлт ХХК (2022)				
10	Дөлгөөн дэлгэрэх ХХК				
11	Дөл энх жин карго ХХК				
12	Хан цайз ХХК				

Улс хоорондын илгээлтийн үйлчилгээг нийт 13 улсад үзүүлж байгаагаас АНУ, БНСУ-ын чиглэлд хамгийн олон үйлчилгээ эрхлэгч үйлчилгээ үзүүлэхээр зөвшөөрөл авсан байна.

*Хүснэгт 43. Улс хоорондын илгээлтийн үйлчилгээ үзүүлж буй чиглэл, үйлчилгээ эрхлэгчийн тоо*

№	Илгээлт хүргэж буй чиглэл, улс	Илгээлтийн үйлчилгээ эрхлэгчийн тоо	№	Илгээлт хүргэж буй чиглэл, улс	Илгээлтийн үйлчилгээ эрхлэгчийн тоо
1	АНУ	27	8	БНЧУ	2
2	БНСУ	26	9	Австрали	2
3	БНТУ	9	10	ИБУИНВУ	2
4	ХБНГУ	8	11	Польш	1
5	БНХАУ	5	12	Франц	1
6	Швед	3	13	Сингапур	1
7	Япон	2			

### 11.1 Шуудангийн үйлчилгээний орлого


Шуудангийн үйлчилгээний нийт орлого 2022 онд 48.9 тэрбум болж, өмнөх оноос 36,6 хувиар нэмэгдсэн бол төсөвт төвлөрүүлсэн орлого буурчээ. Шуудангийн үйлчилгээнд нийт 10.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь 2021 оноос 41.4 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 44. Шуудангийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 2 жилийн өөрчлөлт*

Үзүүлэлт	2021		2022		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	35.75	2.18%	48.86	2.63%	36.6%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	7.79	2.59%	6.69	2.06%	-14.17%
Хөрөнгө оруулалт	6.72	2.41%	10.89	2.97%	41.4%

Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр нийт орлого нэмэгдэж, сүүлийн 3 жилд дунджаар 34 хувийн өсөлттэй байна. Шуудангийн үйлчилгээнд Монгол Шуудан ХК-ийн орлого ихээхэн хувийг эзэлж ирсэн нь сүүлийн жилүүдэд буурч, 2022 онд нийт орлогын 42 хувийг эзэлж байна. (зураг 47)

Зураг 47. Шуудангийн нийт үйлчилгээ эрхлэгчид болон Монгол Шуудан ХК-ийн орлогын харьцуулалт, оноор (сая төгрөг)



Нийт шуудангийн үйлчилгээний орлогод улс хоорондын буухиа шуудан, илгээлтийн үйлчилгээний орлого 56.3 хувийг бүрдүүлж байгаа бол бараа бүтээгдэхүүн захиалгын үйлчилгээний орлого 1.3 хувийг эзэлж байна.

Зураг 48. Шуудангийн үйлчилгээний орлогын бүтэц



## 11.2 Шуудангийн илгээмж солилцоо

Нийт дотоодын шуудангийн илгээмж<sup>2</sup> солилцоо 2022 онд 1 хувиар нэмэгдсэн бол улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо 11.3 хувиар буурчээ.

*Хүснэгт 45. Нийт шуудангийн илгээмж солилцооны тоо*

	2021 он	2022 он
<b>Дотоодын шуудан</b>	3,666,086	3,704,855
<b>Улс хоорондын шуудан</b>	956,723	848,536

*Жич: шуудан солилцооны тоонд орох болон гарах чиглэлийн нийлбэрээр тооцов.*

### 11.2.1 Дотоодын шуудангийн илгээмж солилцоо

Дотоодын шуудангийн илгээмж солилцоог нийт 6 компанийн мэдээлэл бүрдүүлж байгаа ч дийлэнх хувийг Монгол Шуудан ХК-ийн солилцоо эзэлж байна.

Ковидын жилүүдэд буюу 2020, 2021 онд дотоодын илгээлт, боодлын солилцоо 2-3 дахин нэмэгдэж, 2022 онд эргэж буурсан ч ковидын өмнөх жилээс өссөн дүнтэй байна.

*Хүснэгт 46. Дотоодын шуудангийн илгээмж солилцооны тоо*

Илгээмжийн төрөл	Чиглэл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Илгээлт (2-50кг)</b>	Гарах	23,586	22,352	19,305	19,885	45,594	161,499	149,817
	Орох	13,653	15,604	18,908	19,547	41,179	154,254	146,716
<b>Боодол (&lt;2кг)</b>	Гарах	23,664	38,259	50,990	49,124	61,769	166,428	98,109
	Орох	22,856	10,533	49,682	46,973	54,635	154,337	92,058
<b>Бичиг захидал</b>	Гарах	1,076,796	1,162,879	1,490,509	1,616,235	1,978,470	1,805,780	2,002,575
	Орох	607,359	455,979	641,941	745,951	917,645	814,103	932,560

Бичиг захидлын 7 хувь, илгээлтийн 30 орчим хувь, боодлын 4 хувь орчмыг буухиа шуудангаар хүргэж байна.

Дотоодын буухиа шуудангийн илгээлтийн солилцоо 2021 онд огцом нэмэгдсэн нь зах зээлд шинэ тоглогч орж ирсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 47. Дотоодын буухиа шуудан солилцооны тоо*

Илгээмжийн төрөл	Чиглэл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Илгээлт (2-50кг)</b>	Гарах	4,283	4,091	2,709	1,574	1,145	119,386	62,704
	Орох	2,463	2,862	2,690	1,549	852	119,851	62,985

<sup>2</sup> Шуудангийн тухай хуулийн 3.1.3. "шуудангийн илгээмж" гэж үйлчлүүлэгчээс шуудангийн сүлжээ ашиглан, хаягласан эзэнд нь хүргүүлэхээр захидал, боодол, илгээлтийн хэлбэрээр хүлээлгэн өгсөн биет зүйлийг;

<b>Боодол (&lt;2кг)</b>	Гарах	4,889	4,490	4,938	2,642	3,084	4,644	4,173
	Орох	1,539	2,743	4,878	2,601	3,061	4,579	3,617
<b>Бичиг захидал</b>	Гарах	16,354	31,473	39,197	26,639	49,545	81,731	75,591
	Орох	19,538	38,912	38,798	26,067	46,166	79,494	73,950

### 11.2.2 Улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо

Улс хоорондын шуудан солилцоонд бичиг захидлын солилцоо давамгайлдаг байсан бол 2020 онд 4 дахин буурч, ковидын дараа ч дорвитой нэмэгдээгүй байна. Харин илгээлтийн солилцооны орох чиглэл ковидын жилд буюу 2020 онд буурсан ч 2021 оноос 3 дахин нэмэгдэж, улс хоорондын шуудан солилцоонд хамгийн их хувийг эзэлж байгаа нь энэ төрлийн үйлчилгээ эрхлэгчийн тоо нэмэгдэж, цахим худалдаа хөгжиж байгааг нэг талаас харуулж байна.

Улс хоорондын шуудан солилцоонд ерөнхийдөө гадаадаас орох чиглэл нь гарах чиглэлээсээ илүү байдаг байна.

*Хүснэгт 48. Улс хоорондын шуудан солилцооны тоо*

Илгээмжийн төрөл	Чиглэл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Илгээлт (2-50кг)</b>	Гарах	20,228	14,453	15,401	13,784	32,431	132,353	65,460
	Орох	107,040	135,237	204,701	219,227	145,887	463,933	442,174
<b>Боодол (&lt;2кг)</b>	Гарах	8,233	12,398	11,287	10,973	7,989	18,954	11,022
	Орох	89,403	143,801	123,875	143,330	190,525	148,816	74,837
<b>Бичиг захидал</b>	Гарах	183,284	181,403	152,090	163,731	23,872	13,180	29,850
	Орох	108,373	108,896	112,498	111,343	39,279	52,092	56,881

Улс хооронд бичиг захидлын 50 хувь, илгээлтийн 13 орчим хувь, боодлын 7 хувь орчмыг буухиа шуудангаар хүргэж байна.

Улс хоорондын буухиа шуудан солилцоо ковидын улмаас 2020 онд буурч, 2021 оноос буцаж өсчээ.


*Хүснэгт 49. Улс хоорондын буухиа шуудан солилцоо*

Илгээмжийн төрөл	Чиглэл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Илгээлт (2-50кг)</b>	Гарах	31,477	23,681	24,020	25,550	18,452	26,608	29,850
	Орох	52,347	57,661	52,142	44,222	23,025	23,101	56,881
<b>Боодол (&lt;2кг)</b>	Гарах	8,375	6,366	6,033	6,695	9,037	12,382	10,192
	Орох	32,847	39,745	38,756	45,472	35,010	62,765	65,271
<b>Бичиг захидал</b>	Гарах	1,475	1,658	2,424	1,145	1,308	1,011	920
	Орох	10,013	7,590	8,086	5,894	907	1,528	5,198

## 12. Хүний нөөц

Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад 2022 оны байдлаар нийт 12688 ажилтан ажиллаж байгаа нь өмнөх оноос 8.7 хувиар өсчээ. Энэ нь 10 жилийн өмнөхтэй харьцуулбал 50 орчим хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 49. Нийт ажилтны тоо, оноор



Ажиллагсдын тоог салбар, үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл үүрэн холбооны үйлчилгээнд хамгийн их буюу 23 орчим хувь нь ажиллаж байна. “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ”-н дэх ажилтны тоо хүний нөөцийн өсөлтөд гол нөлөө үзүүлсэн бол зарим үйлчилгээ, тухайлбал суурин интернэт, телевиз, радиогийн үйлчилгээний ажилтны тоо бага зэргээр буурчээ.

Хүснэгт 50. Нийт ажилтны тоо, салбар болон үйлчилгээний төрлөөр

Салбар	Үйлчилгээний төрөл	2021 он		2022 он		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тоо	Нийт дүнд эзлэх хувь	Тоо	Нийт дүнд эзлэх хувь	
Мэдээлэл холбоо	Үүрэн холбоо	2649	22.69%	2988	23.55%	12.80%
	Мэдээлэл холбооны сүлжээ	1965	16.83%	1919	15.12%	-2.34%
	Суурин холбоо	812	6.96%	807	6.36%	-0.62%
	Суурин интернэт	627	5.37%	547	4.31%	-12.76%
	Сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ	959	8.22%	1627	12.82%	69.66%
	Сансрын холбоо	50	0.43%	30	0.24%	-40.00%
Өргөн нэвтрүүлэг	Өргөн нэвтрүүлгийн ТВ	1371	11.75%	1358	10.70%	-0.95%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	673	5.77%	589	4.64%	-12.48%
	ОСДҮ - IPTV	572	4.90%	661	5.21%	15.56%
	ОСДҮ – Хиймэл дагуул, КаТВ	420	3.60%	476	3.75%	13.33%

	Арилжааны радио	158	1.35%	138	1.09%	-12.66%
Шуудан	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	1410	12.08%	1542	12.15%	9.36%
	Нийт	11673	100.00%	12688	100.00%	8.70%

### 1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг

9.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
9.1.тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
9.2.арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.3.мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.4.харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.5.олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.6.олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.7.өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.8.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.9.радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.10.сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.11.харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.12.харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.13.дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.14.төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.15.улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо

2. ААҮАТЗ тухай хууль болон Зөвшөөрлийн хуулин дахь харилцаа холбооны тусгай зөвшөөрлийн төрөл, харьцуулалт

№	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	№	Зөвшөөрлийн тухай хууль
	<b>15.16. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:</b>		<b>9.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр</b>
1	15.16.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;	1	9.8.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах
2	15.16.2.харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх.	2	9.4.харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх
		3	9.10.сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх
		4	9.11.харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх
		5	9.12.харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
		6	9.13.дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх
		7	9.15.улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх
		3	15.16.3.контентийн үйлчилгээ эрхлэх.
4	15.16.5.радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;	9	9.9.радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх
	15.16.6.радио, телевизийн үйлчилгээ:		
5	15.16.6.а.олон нийтийн радио, телевиз;	10	9.5.олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх
6	15.16.6.б.арилжааны радио, телевиз;	11	9.2.арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх
7	15.16.6.в.өргөн нэвтрүүлгийн радио, телевиз;	12	9.7.өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх
8	15.16.6.г.төлбөртэй радио, телевиз.	13	9.14.төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэх
9	15.16.7.олон суваг дамжуулах үйлчилгээ.	14	9.6.олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх

3. Хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр, 2022 он

Байршлаар	Хүн ам	Өрх	Идэвхитэй хэрэглэгчийн тоо		
			Үүрэн холбоо	Суурин интернэт	ОСДҮ
НИЙТ	<b>3,457,548</b>	<b>941,547</b>	<b>4,835,520</b>	<b>432,576</b>	<b>760,028</b>
<b>БАРУУН БҮС</b>	<b>418,707</b>	<b>110,046</b>	<b>496,994</b>	<b>16,332</b>	<b>66,767</b>
БАЯН-ӨЛГИЙ	114,776	25,952	115,331	3,262	10,277
ГОВЬ-АЛТАЙ	57,098	16,520	75,775	3,140	9,065
ЗАВХАН	71,798	21,668	96,855	1,698	11,962
УВС	83,964	22,369	100,504	3,475	12,581
ХОВД	91,071	23,537	108,529	4,757	22,882
<b>ХАНГАЙН БҮС</b>	<b>603,427</b>	<b>177,586</b>	<b>699,208</b>	<b>38,583</b>	<b>116,235</b>
АРХАНГАЙ	93,149	28,219	106,301	2,771	15,546
БАЯНХОНГОР	88,397	26,737	101,542	5,691	15,174
БУЛГАН	61,161	19,098	67,677	1,904	10,688
ОРХОН	109,125	29,292	122,957	17,536	29,830
ӨВӨРХАНГАЙ	114,962	34,436	124,998	3,693	21,034
ХӨВСГӨЛ	136,633	39,804	175,733	6,988	23,963
<b>ТӨВИЙН БҮС</b>	<b>515,771</b>	<b>153,339</b>	<b>714,728</b>	<b>46,636</b>	<b>107,025</b>
ГОВЬСҮМБЭР	18,007	5,265	21,517	2,436	4,066
ДАРХАН -УУЛ	107,932	29,503	128,055	14,888	21,641
ДОРНОГОВЬ	71,129	21,265	99,818	6,943	15,886
ДУНДГОВЬ	46,387	14,892	57,254	2,536	8,607
ӨМНӨГОВЬ	72,937	23,712	164,382	8,226	17,656
СЭЛЭНГЭ	107,341	29,966	124,409	8,018	20,567
ТӨВ	92,038	28,736	119,293	3,589	18,602
<b>ЗҮҮН БҮС</b>	<b>227,877</b>	<b>69,576</b>	<b>304,501</b>	<b>14,030</b>	<b>45,076</b>
ДОРНОД	83,704	24,919	102,530	7,073	18,075
СҮХБААТАР	65,214	19,131	83,587	3,093	12,353
ХЭНТИЙ	78,959	25,526	118,384	3,864	14,648
<b>УЛААНБААТАР</b>	<b>1,691,766</b>	<b>431,000</b>	<b>2,620,089</b>	<b>316,995</b>	<b>424,925</b>